

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2018 оны жилийн эцэс/**

2019 оны 1 дүгээр сар 14

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2018 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан журмыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, заалтыг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын 6-р хавсралтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

2018 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан нийт 139 шийдвэрийн 200 заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт **87,8** хувийн биелэлттэй дүгнэв.

Үүнд Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 10 шийдвэрийн 11 заалтын хэрэгжилт 92,2%, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 24 шийдвэрийн 31 заалтын хэрэгжилт 81,3%, Уул уурхайн бодлогын 44 шийдвэрийн 55 заалтын хэрэгжилт 78,1%, Хүнд үйлдвэрийн бодлогын 24 шийдвэрийн 38 заалтын хэрэгжилт 68,4%, Нийтлэг асуудлын 60 шийдвэрийн 102 заалтын хэрэгжилт 98,4%-ийн тус тус биелэлттэй байна. хүснэгт-1

Нийт 162 шийдвэрийн 237 заалтын 34 нь үнэлэх боломжгүй, үнэлгээ өгөөгүй болно.

Хэрэгжилт гаргаж дүгнэсэн 203 заалтын 146 заалт буюу 71,9% бүрэн биелсэн, 57 заалт буюу 28,0% хэрэгжилтийн шатанд 70 хувийн биелэлттэй, 19 заалт буюу 9,3% нь хэрэгжилт удаашралтай байна. хүснэгт-2

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Хууль тогтоомжийн төрлөөр  
/2018 оны жилийн эцэс/

Хүснэгт-2

	Бүгд	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	ЗГ-ын тогтоол	ЕС-ын захирамж	ЗГ-ын хурал дааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	
Хяналтанд авагдсан шийдвэрийн тоо	162	7	7	5	4	6	67	11	54	1	
Заалтын тоо	237	11	9	8	9	9	96	11	72	12	
Үүнээс	Биелсэн 100%	146	6	4	6	5	3	59	3	48	12
	Хэрэгжих шатанд 70.0%	38	4	3	2	2		13	4	10	
	Хэрэгжилт хангалтгүй 30.0%	19	1	1			1	7	2	7	
	Хэрэгжээгүй 0%										
	Дүгнэгдээгүй Үнэлгээ	34		1		2	5	17	2	7	
	87,8	82,7	80,0	92,5	91,4	82,5	88,8	71,1	87,8	100,0	

Эрх зүйн актын хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 7 хуулийн 11 заалтаас бүрэн хэрэгжсэн 6, хэрэгжих шатанд 4, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 82,7%-тай;
- Улсын Их Хурлын 7 тогтоолын 9 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хэрэгжих шатанд 3, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 80,0%-тай
- УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 8 заалтаас бүрэн хэрэгжсэн 6, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 92,5%-тай
- Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 9 заалтаас бүрэн хэрэгжсэн 5, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 91,4%-тай
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 6 шийдвэрийн 9 заалтаас бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 82,5%-тай
- Засгийн газрын 67 тогтоолын 96 заалтаас бүрэн хэрэгжсэн 59, хэрэгжих шатанд 13, хэрэгжилт удаашралтай 7, хэрэгжилтийн дундаж 88,8%-тай
- Ерөнхий сайдын 11 захирамжийн 11 заалтаас бүрэн хэрэгжсэн 3, хэрэгжих шатанд 4, хэрэгжилт удаашралтай 2, хэрэгжилтийн дундаж 71,1%-тай

- Засгийн газрын хуралдааны 54 тэмдэглэлийн 72 заалтаас бүрэн хэрэгжсэн 48, хэрэгжих шатанд 10, хэрэгжилт удаашралтай 7, хэрэгжилтийн дундаж 87,8%-тай
- Засгийн газрын 1 албан даалгаврын 12 заалт бүрэн хэрэгжсэн 100%-ийн тус тус биелэлттэй байна.

### **Дөрөв. Дүгнэлт.**

1. Яамны холбогдох газруудаас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлэх, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

2. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх шийдвэрийн биелэлт хангалтгүй, тухайн асуудлаар толгойлон эсвэл хамтран хэрэгжүүлэгчээс санал авч, хамтарч биелэлтийг тайлагнадаггүй байдал давтагдаж байна.

3. ЗГХЭГ нь 2017 оны жилийн эцэст хүргүүлсэн тайлангаас бүрэн хэрэгжиж дууссан, чиг үүргийн хувьд тус яамны эрхлэх асуудалд хамааралгүй шийдвэрүүд, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, сүүлийн 3 жил тасарсан, удааширсан, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах талаар тухай бүр арга хэмжээ авч, холбогдох шийдвэрийг гаргуулж байх шаардлагатай байна.

4. Яамны эрхлэх асуудалд хамааралгүй, хэрэгжих хугацаа болоогүй, үндсэн хэрэгүүлэгч яамнаас санал ирээгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, тухайн шийдвэр хүчингүй болсон, тухайн асуудлаар шинээр шийдвэр батлагдсан, хуульд нэмэлт, өөрчлөлт орж, тухайн шийдвэр дэх харилцаа цаашид үргэлжлэх боломжгүй болсон зэрэг 34 заалтад үнэлгээ өгөөгүй.

5. Салбарт баримтлах бодлогын баримт бичгийг баталсан тогтоолын биелэлт гаргахад бэрхшээлтэй байна. Тухайлбал “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого” баталсан УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоол, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлог”-ыг баталсан УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол, “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” баталсан ЗГ-ын 2017 оны 98 дугаар тогтоол, “Хөгжлийн зам” хөтөлбөрийг баталсан ЗГ-ын 2017 оны 142 дугаар тогтоол, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталсан ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолын заалтууд нь урт болон дунд хугацаанд хэрэгжих томоохон зорилтуудыг агуулж байх бөгөөд батлагдсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон журмаар зохицуулагдаж байгааг анхаарч хяналтаас хасах нь зүйтэй байна.

6. Зэсийн баяжмал боловсруулах, нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, удаашралтай, бодит үр дүн гараагүй байна.

7. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталсан УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор Аж үйлдвэрийн яам /хуучнаар/-ны эрхлэх зарим асуудал нь ХХААХҮЯ, ГХЯ, Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарч байх ба УУХҮЯ-ны хяналтаас хасуулах шаардлагатай байна.

8. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, үнэ, хангамжийн асуудлаар батлагдсан, нэг удаагийн зохицуулалттай шийдвэрүүд хяналтаас хасагдахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

### Тав. Зөвлөмж.


1. Удаашралтай ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа шийдвэр, заалтыг хүчингүй болгох, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.
2. Төрийн захиргааны удирдлагын газар хяналтанд авагдаж буй шийдвэрийг тухай бүрт нь хариуцах нэгж, албан хаагчийг эзэнжүүлэхэд анхаарах.
3. Төрийн өмчит компаниас холбогдолтой шийдвэрийн хэрэгжилтийг гаргуулж авахад анхаарах
4. Холбогдох нэгжүүд ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн боловсруулалт, чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар хянаж ирүүлэх.
5. Дотоод нэгжүүд биелэлтийг тогтоосон хугацаанд гаргах, шинэчилж ирүүлж байх,
6. Холбогдох нэгжүүд дүгнэгдээгүй, удааширсан шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.
7. Хяналтаас хасуулах нийт 150 заалтыг 2018 оны жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлэх.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:  
ХШҮДАГ-ын дарга  Г.Ганхүү


Үнэлгээ хийж тайлан, танилцуулга боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн  Б.Баяржаргал

Мэргэжилтэн  Н.Баатар

Мэргэжилтэн  Н.Цогтбаяр

Мэргэжилтэн  Г.Батнайрамдал

Мэргэжилтэн  Д.Болортуяа

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ  
/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2019.01.15

Салбар, чиглэлин нэр	Хяналтанд		Хэрэгжилтийн явц				үнэлээ гүй	Үнэлгээ /%/
	шийд вэр	зүйл заалт	100%	70%	30%	0%		
<b>НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	1	1	1	-	-	-	-	100.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	1	1	-	-	-	-	100.0
Засгийн газрын тогтоол	7	8	6	-	-	-	2	100.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	1	1	-	-	1	-	-	30.0
ГЭББ-ын дүн	10	11	8	-	1	-	2	92.2
<b>ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	1	4	3	-	1	-	-	82.5
УИХ-ын тогтоол	1	1	1	-	-	-	-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	1	1	-	-	1	-	-	30.0
Засгийн газрын тогтоол	10	12	7	2	1	-	2	87.0
Ерөнхий сайдын захирамж	1	1	-	-	1	-	-	30.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	10	12	8	2	2	-	-	83.3
ПТГТБТНТБ-ын дүн	24	31	19	4	6	-	2	81.3
<b>ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	2	2	-	2	-	-	-	70.0
УИХ-ын тогтоол	2	3	1	2	-	-	-	80.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	5	3	2	-	-	-	88.0
Ерөнхийлөгчийн зарлиг	2	7	3	2	-	-	2	88.0
Засгийн газрын тогтоол	16	19	5	4	3	-	7	72.5
Ерөнхий сайдын захирамж	4	4	-	2	1	-	1	56.6
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	15	15	6	5	1	-	3	81.6
УУБ-ын дүн	44	55	18	19	5	-	13	78.1
<b>ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	1	1	-	1	-	-	-	70
УИХ-ын тогтоол	2	3	1	-	1	-	1	65
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	3	6	1	-	-	-	5	100
Засгийн газрын тогтоол	10	16	5	4	3	-	4	72.5
Ерөнхий сайдын захирамж	2	2	-	2	-	-	-	70
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	6	10	1	3	3	-	3	57.1
ХҮБ-ын дүн	24	38	8	10	7	-	13	68.4
<b>ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ</b>								
Монгол Улсын хууль	2	3	2	1	-	-	-	90.0
УИХ-ын тогтоол	2	2	1	1	-	-	-	85.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	2	2	-	-	-	-	100.0
Ерөнхийлөгчийн зарлиг	2	2	2	-	-	-	-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	2	2	2	-	-	-	-	100.0
Засгийн газрын тогтоол	24	41	36	3	-	-	2	97.6
Ерөнхий сайдын захирамж	4	4	3	-	-	-	1	100.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	22	34	33	-	-	-	1	100.0
ЗГ-ын албан даалгавар	1	12	12	-	-	-	-	100.0
Нийтлэг асуудлын дүн	60	102	93	5	-	-	4	98.4
<b>Эрх зүйн баримт бичгийн дүн</b>	<b>162</b>	<b>237</b>	<b>146</b>	<b>38</b>	<b>19</b>	<b>-</b>	<b>34</b>	<b>87.8</b>

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ  
/2018 оны жиийн эцэс/**

2019 оны 01 дүгээр сарын 14

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<b>Салбар чиглэл: 1 – ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО</b>					
<b>1.а. Монгол Улсын хууль</b>					
1	1	<p align="center"><b>ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ</b> 2014-01-09</p> <p>3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.</p>	Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 222 дугаар тогтоолоор Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг хавсралтаар баталсан.	100	Хуулийн заалт бүрэн хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
<b>1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол</b>					
1	1	<p align="center">Засгийн газарт чиглэл өгөх тухай</p> <p align="center">2015-04-22</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2011 оны 175 дугаар тогтоол Газрын тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцэхгүй байх тул хуульд нийцүүлэн өөрчлөх, эсхүл хүчингүй болгохыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай.</p>	Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолыг Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.7 дэх хэсэгтэй нийцүүлсэн.	100	Тогтоолын заалт 100% хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

1.е.Засгийн газрын тогтоол					
1	1	Талбайг нөөцөөс чөлөөлөх тухай 2016-04-18 №214  2. Нөөцөөс чөлөөлсөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших "Оюут уул", Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших "Эрдэнэт-Зүүн хойд-3" талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Ашигт малтмал газрын тосны Ашигт малтмал газрын тосны газрын дарга Д.Үүрийнтуяад даалгасугай.	"Эрдэнэтийн зэс-молибдений ордын талбайн хил заагийг тогтоох тухай" Засгийн газрын 2017 оны 255 дугаар тогтоолд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших "Оюут уул" талбай хамрагдсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн Овоо ордын талбайн хил заагийг шинэчилэн тогтоох тухай саналыг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2018 оны 300 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших "Эрдэнэт-Зүүн хойд-3" талбай нь Эрдэнэтийн ордын талбайн хил заагт хамрагдах болсон.	100	Тогтоол хэрэгжих эрх зүйн үндэс бүрдсэнээр тогтоолын заалт биелсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
2	2	Талбайн солбицол тогтоох тухай 2017-01-25  2. "Алт-2" үндэсний хөтөлбөртэй уялдуулан алтны нөөцийг өсгөж олборлолтыг дэмжих, нөхөн сэргээлтийн ажлыг иж бүрэн хэрэгжүүлэх зорилгоор алтны хэтийн төлөв бүхий нутаг дэвсгэрт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай.	Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг Заамарын болон Сэлэнгийн нутаг дэвсгэрийн хүрээнд хийж хил заагийг тогтоон Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн боловч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санал ирүүлээгүй учир хойшлогдсон.	/-/	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг дагалдан Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох нэмэлт өөрчлөлт орсонтой уялдан цаашид хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
2	3	Талбайн солбицол тогтоох тухай 2017-01-25	Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар	100	

		<p>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлэн ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт үүрэг болгосугай.</p>	<p>олгох нэмэлт өөрчлөлт орсонтой уялдуулан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төслийг шинэчилж боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлан, Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 3863 дугаарт бүртгүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 2017 оны 11 дүгээр сарын нэмэлт өөрчлөлт, түүнтэй холбогдуулан шинэчилэн боловсруулсан журмын дагуу сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайг ялган аймаг орон нутгаас санал авсаны үндсэн дээр Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн “Талбайн солбицол тогтоох тухай” 243 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолоор нийт 237,580 солбицол бүхий 8,489,065.45 гектар талбайг сонгон шалгаруулалтад хамруулахаар тогтоон нийтэд зарлахаар шийдвэрлэсэн байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажил 2018 оны 8-р сарын 22-оос эхлэсэн бөгөөд 12-р сарын 18-ны өдрийн байдлаар 6 багцаар 60-н талбайд 511,189.89 га-д хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласнаас 3 удаагийн /СШ-25, СШ-26, СШ-27, СШ-28/ сонгон шалгаруулалтаар 101,016,61 га бүхий 24-н талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох аж ахуй нэгжийг шалгаруулсан. Үүнээс 12-р сарын 18-ны өдрийн байдлаар 65,254.08 га талбайд 14 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт бодитоор 8,573,359,815.0 төгрөг төвлөрүүлээд байна.</p>	<p>Тогтоолын хэрэгжилт бүрэн биелсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
3	4	<p>Байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай 2017-03-15 №90</p> <p>2. Хилийн заагийг баталсантай</p>	<p>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/110 дугаар тушаалаар нөхөн олговорын хэмжээ тогтоох Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны</p>	<p>100</p> <p>Засгийн газрын тогтоолын заалтууд бүрэн</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид, мэдээллийн санд бүртгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт, хамгаалалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>газар, Татварын ерөнхий газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг нь Засгийн газрын 2017 оны 90, 91 дүгээр тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газарт давхцалтай хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийг судлан, нөхөн олговорын хэмжээг тогтоож, цуцлагдсан тусгай зөвшөөрлийн талбайг дүйцүүлэн олгох тухай асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хэлцэл хийж, дүгнэлт гаргасан байна. Ажлын хэсгийн дүгнэлтэнд үндэслэн гаргасан яамны саналыг Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 256 дугаар тогтоолыг гаргасан байна. Уг тогтоолын дагуу тусгай хамгаалалттай газар нутагт орших давхцал бүхий 9 тусгай зөвшөөрлийг цуцлаж, 18 тусгай зөвшөөрлийг дүйцүүлэн шинээр олгохоор шийдвэлэсний дагуу холбогдох арга хэмжээг АМГТГ авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
4	5	<p>Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай 2017-03-15 №: 2017_91</p> <p>2. Хилийн заагийг баталсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид, мэдээллийн санд бүртгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт, хамгаалалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт тус тус даалгасугай.</p>	<p>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/110 дугаар тушаалаар нөхөн олговорын хэмжээ тогтоох Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг нь Засгийн газрын 2017 оны 90, 91 дүгээр тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газарт давхцалтай хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийг судлан, нөхөн олговорын хэмжээг тогтоож, цуцлагдсан тусгай зөвшөөрлийн талбайг дүйцүүлэн олгох тухай асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хэлцэл хийж, дүгнэлт гаргасан байна. Ажлын хэсгийн дүгнэлтэнд үндэслэн гаргасан яамны саналыг Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн</p>	<p>100</p> <p>Засгийн газрын тогтоолын заалтууд бүрэн хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

			хуралдаанаар хэлэлцэн 256 дугаар тогтоолыг гаргасан байна.Уг тогтоолын дагуу тусгай хамгаалалттай газар нутагт орших давхцал бүхий 9 тусгай зөвшөөрлийг цуцлаж, 18 тусгай зөвшөөрлийг дүйцүүлэн шинээр олгохоор шийдвэлэсний дагуу холбогдох арга хэмжээг АМГТГ авч хэрэгжүүлсэн байна.		
5	6	Талбайн солбицлыг тогтоон нийтэд мэдээлэх тухай 2017-03-29 №: 2017_106  2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлж, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэн тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай.	Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг бүхэлд нь хүчингүй болгон тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгохоор болсон тул өргөдлийн дугаарыг цахим системээр олгох үйл ажиллагааг дахин явуулах эрх зүйн үндэслэлгүй болсон.	/-/  Өргөдлийн дугаарыг цахим системээр олгох үйл ажиллагааг дахин явуулах эрх зүйн үндэслэлгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
6	7	Нөхөх олговрын зориулалтаар олгох тусгай зөвшөөрлийн талбайн солбицол батлах тухай 2017-09-13 №: 2017_256  2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу нөхөх олговор олгож байгаатай холбогдуулан тусгай зөвшөөрөл шинээр олгох болон тусгай хамгаалалттай газарт талбай нь давхацсан аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогтод, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдоржид тус тус даалгасугай.	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд тогтоолын дагуу тусгай хамгаалалттай газар нутагт орших давхцал бүхий 9 тусгай зөвшөөрлийг цуцлаж, 18 тусгай зөвшөөрлийг дүйцүүлэн шинээр олгосон байна.	100  Засгийн газрын тогтоолын заалтууд бүрэн хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

7	8	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зарим талбайн солбицол батлах тухай 2018-10-03 Дугаар 2018_301</p> <p>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.</p>	<p>“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Багц 3 буюу Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын үед замын далан, гүүр болон бусад туслах материалаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал болох дайрганы чулуу, элс, шавар зэрэг ашигт малтмалыг ашиглах талбайн хил заагийг энэхүү тогтоолоор зааж өгсөн байна. Энэхүү замын барилгын ажилд дээрх талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг ашиглаж буй бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар замын ажлын гүйцэтгэл 51%-тай байна Урдчилсан байдлаар Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байна.</p>	100	
1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1	1	<p>2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2014-10-04</p> <p>ХҮИ. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав.</p>	<p>Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдхүүнд салбарын яамнаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, холбогдох агентлагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулсан. Ажлын хэсэг нь хууль эрх зүйн орчин, хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны ажил хийж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Хууль эрх зүй, дотоод хэргийн яаманд хандан Газрын хэвлийн тухай хуулийн давхцал, зөрчил, хийдлийн судалгааг хийлгэсэн. Судалгааг хийсэн хуульчдын багтай хуулийн үйлчлэлийн тухай асуудлаар ажлын уулзалтуудыг удаа хийж, судалгааг дахин хийлгэсэн.</p>	30	

Хэсгийн дундаж: 92,2 хувь

Салбар чиглэл: 2 - ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО

2.а.Монгол Улсын хууль

1	1	<p>ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01</p> <p>7.1.4 нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; газрын тосны салбарыг хөгжүүлэх сан; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;</p>	<p>"Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-ыг Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн ЗГ-ын 5-р тогтоолоор батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Газрын тосны бүртгэл, тооцооны журмын төслийг боловсруулж, дотоодын зөвлөх болон АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс санал авч тусган АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран семинар зохион байгуулж, төслийг хэлэлцүүлсэн. Мөн 2 удаа АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц зохион байгуулж санал солилцсон. Журмын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2018.12.26-ны өдрийн 01/3485 тоот албан бичгээр яамдаас санал авч байна.</p> <p>"Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам"-ыг Засгийн газрын 2015.07.07-ны өдрийн 295-р тогтоолоор батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2015.01.23-ны өдрийн хуулиар "Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан"-г хассан тул журам боловсруулах шаардлагагүй болсон.</p>	100	Бүртгэл тооцооны журам боловсруулж батлуулах ажил удаашралтай, сүүлийн 3-аас дээш удаагийн тайлангаар хэрэгжилтэд ахиц гараагүй байх тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ
	2	<p>ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01</p>	<p>"Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага"-ын төслийг MINIS төслөөс санхүүжүүлэн боловсруулахаар ажлын даалгаврыг боловсруулж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны санаачлагаар Газрын тосны хайгуул, нөөцийн тооцооллын</p>	100	

8.1.3 газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;

ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж, заавар боловсруулахаар Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр ШУТИС-ийн эрдэмтэдийн баг 2018 оны 09 дүгээр сард гэрээ байгуулан ажиллаж байна.

"Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.10-ны 49-р тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.

Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлагыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч төсөлд тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 197 дугаар тушаалаар батлуулсан боловч Захирагааны ерөнхий хуульд батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2014 оны 202-р тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул

			<p>уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлуулсан боловч боловч Захирагааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийг Захиргааны хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/06-р тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.12-ны өдрийн 53-р тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.</p>		
3		<p>ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01</p> <p>8.1.8 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;</p>	<p>“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг боловсруулах БОНХАЖ /хуучин нэрээр/, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.03.24-ний өдрийн 62/А-131 дугаар хамтарсан тушаалаар байгуулж, төслийг боловсруулан БОНХАЖ-ийн /хуучин нэрээр/ сайдын зөвлөл, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. УУС-ын /хуучин нэрээр/ тушаалаар батлуулж, журмын дагуу Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд бүртгүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлж хүргүүлсэн боловч Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан. Тус журмын төслийг Захиргааны хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 дугаар тушаалаар батлуулж, яамны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.</p>	100	

	4	<p>ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</p> <p>2014-07-01</p> <p>8.1.9 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;</p>	<p>АМГТГ-аас боловсруулж ирүүлсэн Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран 2018 оны 3-р сарын 21-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс гаргасан саналыг дүрмийн төсөлд тусгах, дүрмийн бүтэц, агуулгыг сайжруулах, Монгол улсын хууль тогтоомж, олон улсын болон Монгол улсын стандартуудтай уялдуулан шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна. Мөн энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS JIS 45001-2018 45х стандарт батлагдсан, газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн мөрдөн ажиллаж буй олон улсын стандартуудыг орчуулах, уялдуулах зэрэгтэй холбоотойгоор өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлага үүсээд байна.</p>	30	
2.б.Улсын Их Хурлын тогтоол					
1	1	<p>Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан</p> <p>2016-11-17</p> <p>№69</p> <p>2/2. түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд</p>	<p>Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмыг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна. Газрын тосны борлуулалтын орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцож 2017 онд 31.7 тэрбум төгрөгийн 2018 онд 33.5тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Газрын тосны борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг</p>	100	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.	бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.  Газрын тосны тухай хуулийн 11.2.6. дугаар зүйлд “хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах” гэсэн заалтыг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 104 дүгээр тогтоолоор загвар Бүтээгдэхүүн хуваах гэрээний 15 дугаар зүйлд тусган баталгаажуулсан. Загвар гэрээний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 11 компаний БХГ-г шинэчлэн батлаж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байна.		
2.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл					
1	1	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай  2014-10-20  №2014_52/30  2.5 Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх	Газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээг АМГТГ болон Австрали улсын хөрөнгө оруулалттай Жи Өү Эйч ХХК-ийн хооронд 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулаад байна. БНХАУ, ОХУ-аас байгалийн хий импортлон, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшээр хангах төсөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа Ю Би Метан ХХкомпанид байгалийн хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.	30	
2.е.Засгийн газрын тогтоол					
1	1	Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох тухай  2015-11-02 №431	Газрын тосны хайгуулын Тариач-XV талбайд Газрын тосны газар /хуучин нэрээр/, “Чайна Голден Сий Петролеум Эксплорейшн Корпорейшн” ХХК-ийн хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-г Засгийн газрын 2015 оны 431 дүгээр тогтоол, Газрын тосны газар /хуучин нэрээр/-ын даргын 2015 оны 162-р	70  Хэрэгжилт удаашралтай, сүүлийн 3 удаагийн тайлангаар бодит үр дүн гараагүй тул	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарахтай холбогдон удааширсан.

		<p>2 Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлан газрын тосны тухай хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай.</p>	<p>тушаалаар цуцалсан боловч 2017 онд НЗХАШ-ны шүүхийн шийдвэрээр БХГ-г сэргээхээр болсон. АМГТГ-аас гэрээний хэрэгжилтийг дүгнэж, НЗХАШ-ны шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.</p>	<p>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
2	2	<p>Хөтөлбөр батлах тухай</p> <p>2017-03-20 №98</p> <p>3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. 4.2.12. “Нүүрсний давхаргын метан хийн нөөцийн судалгааг эрчимжүүлж, нүүрс баяжуулах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах үйл ажиллагааг дэмжих”, 4.3.2. “Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах”</p>	<p>4.2.12. -Багануурын нүүрсний уурхайг түшиглэн жилд 725 сая.м3 нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Шинжлэх Ухаан Техникийн Зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцэн хүлээж авсан. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төслийн байгаль орчны үнэлгээний ажлыг Green Trend ХХК гүйцэтгэж байна. Хөрөнгө оруулалтын чиглэлээр гадны хөрөнгө оруулагчидтай уулзалт, хэлэлцээр хийсэн ба хөрөнгө оруулагчид хамтран ажиллах хувилбар, саналаа илэрхийлээд байна. Газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээг АМГТГ болон Австрали улсын хөрөнгө оруулалттай Жи Эү Эйч ХХК-ийн хооронд 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулаад байна.</p> <p>4.3.2 - Шатахууны онцгой албан татварын хэмжээг чанар стандарттай уялдуулан тогтоох, чанарын шаардлага хангахгүй автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортлож буй үндсэн /керосин, нафта зэрэг/ болон нэмэлт бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах хууль, эрхзүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сард Сангийн яаманд, 2018 оны 05 дугаар сард БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн. Мөн Онцгой албан татварын хэмжээг газрын тосны бүтээгдэхүүний төрөл, чанар, стандарт, импортлож буй боомттой</p>	<p>100</p> <p>Хөтөлбөрийн биелэлтийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох журмын хүрээнд тайлагнах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	

			<p>уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчин бүрдүүлэх, Агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун борлуулахыг хориглох эрхзүйн орчин бүрдүүлэх асуудлуудыг 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 18/03-1 дугаар тогтоолд тусгуулсан.</p> <p>- Евро-5 стандартад нийцсэн шатахууны хэрэглээг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг Улаанбаатар хотын бүсэд жижиглэнгээр борлуулахыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хориглох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох материалыг боловсруулан бүх яамд, нийслэлээс саналыг авч нэгтгэн тус асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр 2018 оны 03 дугаар сард ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй автобензин, дизель түлшний борлуулалтыг хориглосон шийдвэр гаргах нь одоо мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж стандартуудтай зөрчилдөх нөхцөл байдал үүсэх, Сангийн сайд ЗГ-ын тогтоолын төслийг дэмжихгүй санал өгсөн зэрэг үндэслэл, шалтгаанаар буцаасан.</p> <p>-Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 201 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг холбох танилцуулгын хамт 2018.12.28-ны өдрийн 01/3502 тоот албан бичгээр Шадар сайд Ө.Энхтүвшинд хүргүүлсэн.</p>		
--	--	--	---	--	--

			<p>- Роснефть компаний төлөөлөлтэй хийсэн уулзалт хэлэлцээрүүдийн үеэр Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй үнээр худалдах боломжийн талаар хэлэлцэн, тодорхой тохиролцоонд хүрээд байна.</p> <p>- “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан Хууль, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн. Шинэчлэсэн журмаар чанарын шаардлага хангахгүй автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортлож буй үндсэн /керосин, нафта зэрэг/ болон нэмэлт бүтээгдэхүүнийг зөвхөн үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж импортлох бөгөөд тусгай зөвшөөрөл дээр тухайн бүтээгдэхүүний БТКУС кодыг тэмдэглэж байх зохицуулалт хийсэн. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг АМГТГ, ГЕГ, МХЕГ, газрын тосны бүтээгдэхүүний импорт, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд болон холбогдох байгууллагуудад батлагдсан журмын хамт явуулсан.</p> <p>- Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанарт хяналт, шалгалт хийх УУХҮЯ, АМГТГ, МХЕГ-ын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буй нэр бүхий 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүний чанарт хяналт шалгалт хийж тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.</p> <p>- Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт-шинжилгээний Олон улсын туршлага судлах, сургалт судалгааны чиглэлээр АМГТГ болон БНСУ-ын Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамжийн газар /К-Петро/ хооронд “Техникийн</p>		
--	--	--	--	--	--

			<p>Хамтын Ажиллагааны САНАМЖ БИЧИГ"-ийг байгуулан хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын К-Петро байгууллагатай хамтран 2018 оны 09 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд “Шатахууны чанарын хяналтын менежментийн систем, технологи, БНСУ-ын туршлага” сэдэвт семинарын зохион байгуулсан ба тус семинарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын 120 төлөөлөгч оролцлоо.</p> <p>- АМГТГ-ын дэргэдэх Уул уурхай, газрын тосны төв лаборатори нь Эрдэс баялгийн сорилтын лабораторийн итгэмжлэлийн техникийн хорооны 2018 оны 05 дугаар сарын 03-ны хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ гүйцэтгэх итгэмжлэл аваад байна.</p>		
3	3	<p>Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2017-10-03 №297</p> <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт даалгасугай.</p>	<p>Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АМГТГ нь газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгжтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг 2018.01.25-ны өдөр байгуулсан. 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх 21 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг агуулахын байршлуудаар нь нэгтгэн Төв, Баруун, Зүүн гэсэн 3 бүст хуваан хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн эхний сарын нөөцийг 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авсан. Улсын хэмжээнд 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг сар бүр дунджаар 30 хоногийн нөөцийг бүрдүүлэн ажилласан. 2018 онд Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж тасралтгүй, нөөц хэвийн байсан.</p>	100	<p>Тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдсан, нөөцийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Нэг удаагийн зохицуулалттай шийдвэр тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>
	4	<p>3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэж улсын нөөцөд 94 700 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх</p>	<p>2012 оны төсвийн хөрөнгө болон ЗГ-ын эрсдлийн сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн 12.7 мянган тонн улсын нөөцийн шатахууныг ААН-үүдтэй сэлгэх гэрээ байгуулан хадгалуулж байна. УУХҮСайдын 2018.06.18-ны өдрийн 01/1670 албан тоотыг</p>	/-/	<p>Хэрэгжих боломжгүй, 2012 оноос хойш</p>

		<p>хэмжээний газрын тосны бүтээгдэхүүн бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Дашдорж нарт даалгасугай.</p>	<p>АМГТГ-т хүргүүлж, “Ник” ХХК, “Шунхлай групп” ХХК, “Монсуль” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Ойн бирж” ХХК-иудтай байгуулсан гэрээг 2019.05.01-нийг хүртэл сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэх талаар холбогдох саналаа СЯ-нд 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 01/2348 тоот албан бичгээр, 2018 оны улсын төсөвт шаардагдах хөрөнгийг суулгахаар холбогдох тооцоо, танилцуулгыг яамны төсвийн саналд хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. Иймд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй байдаг.</p>	<p>шаардагдах санхүжилтийн саналыг хүргүүлж ирсэн боловч шийдэгддэггүй тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ, ЭСВЭЛ САНАЛТАЙ. САНГИЙН ЯАМНААС БИЕЛЭЛТИЙГ АВАХ НЬ ЗҮЙТЭЙ.</p>	
4	5	<p>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2017-11-15 №:309</p> <p>2. Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний хангамж, нийлүүлэлт, жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва нарт үүрэг болгосугай.</p>	<p>Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөн, төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан, автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг үе шаттайгаар нэмэгдсэн зэргээс хамааран шатахууны жижиглэн борлуулалтын үнэ нэмэгдэх нөхцөл үүссэн тул тулгамдаж буй асуудлыг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. 2018.02.23-ны өдрийн ЗГ-ын хуралдааны 59 дүгээр тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн ээлжит хуралдааныг 2018 оны 1, 6, 10 дугаар сард тус тус зохион байгуулж, холбогдох зөвлөмжийг гарган хэрэгжүүлж ажиллав. Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 маркийн автобензиний онцгой албан татварын хэмжээг “0”-лэн ижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан. Мөн импортлогч компаниудын татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар шатахууны жижиглэнгийн</p>	<p>100</p> <p>2018.10.03.-ны өдрийн ЗГ-ын хуралдааны 20 дахь асуудал Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэн 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС</p>	

		<p>борлуулалтын үнийг тогтвортой хадгалж ирсэн хэдий ч татварын зохицуулалтыг хийснээс хойш өөр нэмэлт өөрчлөлт, зохицуулалтыг хийгээгүй тул гадаад зах зээлийн үнийн хэлбэлзэл, валютын ханшийн өсөлтөөс жижиглэн борлуулах үнэ 2018 оны 2 дугаар сараас хойш бүс нутгаас хамааран литр тутамдаа 300 орчим /270-353/ төгрөгөөр нэмэгдсэн. Харин 2018 оны 11 дүгээр сараас дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурсантай холбоотойгоор 12 дугаар сард нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ өмнөх сартай харьцуулбал тонн тутамдаа 82-148 ам доллараар буурч орж ирсэн нь сарын дунд үеэс жижиглэнгийн үнэд эерэгээр /литрт тутамд ДТ-50₮ орчим, автобензин-200₮ орчим/ нөлөөлөхөөр байсан. Иймээс газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны үнээ бууруулах шаардлагыг тавьж, 2018.12.07-ны өдрөөс Аи-92 автобензиний үнийг зарим томоохон аж ахуйн нэгжүүд 100 орчим төгрөгөөр бууруулаад байна.</p> <p>-УУХҮЯ-наас 2017, 2018 онуудад Роснефть компанийн удирдлагуудтай хийсэн удаа дараагийн уулзалтаар газрын тосны бүтээгдэхүүн импортлогч ААН-үүдийн “Бүтээгдэхүүн нийлүүлэх үндсэн гэрээ”-нд заасан үнэ тооцох томъёололд өөрчлөлт оруулж, 2018.05.01-ний өдрөөс бүс нутаг, бүтээгдэхүүний төрлөөс хамааран шатахууны үнийг 20-40 ам.доллараар бууруулахаар тохиролцсон.</p> <p>-2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн агуулах, шатахуун түгээх станцуудын үйл ажиллагаа болон шатахууны жижиглэнгийн үнэд өөрчлөлт орсон эсэхэд үзлэг,</p>	<p>ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
--	--	--	-------------------------------	--

			шалгалт хийж 605 ШТС-/давхардсан тоогоор/-ыг хамруулж, шалгалтын мэдээ, тайланг нэгтгэсэн.		
5	6	<p>Журам батлах тухай “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”</p> <p>2018-01-03 №: 2018_5</p> <p>2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлагдсан “ Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам” –ын дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК, Доншен газрын тос /Монгол/ ХХК-ний Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайгаас олборлож, борлуулсан түүхий тосны орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцож 2017 онд 31.7 тэрбум төгрөгийн 2018 онд 33.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Дээрх орлогын 70 хувийг Улсын төсөвт, үлдэх хэсгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилах тооцоог сар бүр хийж Сангийн яаманд хүргүүлж байна.</p> <p>Тусгай зөвшөөрлийн төлбөрт 2018 онд нийт 1,935.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Журмын дагуу тус орлогын 70 хувь буюу 1,354.5 сая төгрөгийг Улсын төсөвт, 20 хувь буюу 387.0 сая төгрөгийг газрыг тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй тухайн аймгийн төсөвт 10 хувь буюу 193.5 сая төгрөгийг сумын төсөвд хуваарилах тооцоог сар бүр хийж Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	100	<p>Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>
6	7	<p>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай</p> <p>2018.01.24 №26</p> <p>2.Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний хангамж нийлүүлэлтийг тасалдалгүй, жижглэнгийн үнийг тодорхой түвшинд тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж</p>	<p>Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 маркийн автобензиний онцгой албан татварын хэмжээг “0”-лэн тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан. Мөн импортлогч компаниудын татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар шатахууны жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой хадгалж ирсэн. Татварын зохицуулалтыг хийснээс хойш өөр нэмэлт өөрчлөлт, зохицуулалтыг хийгээгүй тул гадаад зах зээлийн үнийн хэлбэлзэл, валютын ханшийн</p>	100	<p>2018.10.03.-ны өдрийн ЗГ-ын хуралдааны 20 дахь асуудал Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан</p>

		ажиллахыг болгосугай.	УУХҮС....	нарт	үүрэг	<p>өсөлтөөс жижиглэн борлуулах үнэ 2018 оны 2 дугаар сараас хойш бүс нутгаас хамааран литр тутамдаа 300 орчим /270-353/ төгрөгөөр нэмэгдсэн. Харин 2018 оны 11 дүгээр сараас дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурсантай холбоотойгоор 12 дугаар сард нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ өмнөх сартай харьцуулбал тонн тутамдаа 82-148 ам доллараар буурч орж ирсэн нь сарын дунд үеэс жижиглэнгийн үнэд эерэгээр /литрт тутамд ДТ-50₮ орчим, автобензин-200₮ орчим/ нөлөөлөхөөр байсан. Иймээс газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны үнээ бууруулах шаардлагыг тавьж, 2018.12.07-ны өдрөөс Аи-92 автобензиний үнийг зарим томоохон аж ахуйн нэгжүүд 100 орчим төгрөгөөр бууруулаад байна.</p> <p>-УУХҮЯ-наас 2017, 2018 онуудад Роснефть компанийн удирдлагуудтай хийсэн удаа дараагийн уулзалтаар газрын тосны бүтээгдэхүүн импортлогч ААН-үүдийн “Бүтээгдэхүүн нийлүүлэх үндсэн гэрээ”-нд заасан үнэ тооцох томъёололд өөрчлөлт оруулж, 2018.05.01-ний өдрөөс бүс нутаг, бүтээгдэхүүний төрлөөс хамааран шатахууны үнийг 20-40 ам.доллараар бууруулахаар тохиролцсон.</p> <p>-2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн агуулах, шатахуун түгээх станцуудын үйл ажиллагаа болон шатахууны жижиглэнгийн үнэд өөрчлөлт орсон эсэхэд үзлэг, шалгалт хийж 605 ШТС-/давхардсан тоогоор/-ыг хамруулж, шалгалтын мэдээ, тайланг нэгтгэсэн.</p>	<p>сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэн 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
--	--	-----------------------	-----------	------	-------	---	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

7	8	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг шилжүүлэх тухай</p> <p>2018-04-25 №: 2018_108</p> <p>2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг зохих хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2018.04.25-ны өдрийн 108-р тогтоолоор хайгуулын Эргэл XII талбайн БХГ-ний эрх үүргийг Смарт ойл инвестмент лтд компаниас Смарт петролеум инвестмент лтд-д шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан Газрын тосны тухай хуулийн 14.5 дах хэсэгт заасны дагуу Эрх үүрэг шилжүүлэх гурван талт гэрээнд 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдөр талууд гарын үсэг зурж, эрх үүрэг шилжсэн болно.</p>	<p>100</p> <p>Тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
8	9	<p>Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай 2018-06-06 №169 2.. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.</p>	<p>"Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын төслийг боловсруулж, төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг Сангийн яамнаас авахаар 2018 оны 4-р сарын 20-ны өдрийн 01/1082 тоот албан бичиг хүргүүлж, 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн 5-2/2405 тоотоор зөвшөөрлийг авсан.</p> <p>Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын төсөлд бүх яамдаас саналыг авч, нэгтгэн 2018.05.11-ний өдрийн 01/1298 албан тоот бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Бодлогын төслийг ЗГ-ын 2018.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн ЗГ-ын 169 дүгээр тогтоолоор батлуулсан. Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2018-2027/-г боловсруулж, сайдын тушаалаар батлуулахад бэлэн болоод байна. Төлөвлөгөө батлагдсаны дараа 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах болно.</p>	<p>70</p>	
	10	<p>3. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого" -ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг</p>	<p>"Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого" -ын 2.3.1.6. газрын тосны орд ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, газрын тосны ордын дэд бүтцийг хөгжүүлэх, тээвэрлэлтийн менежментийг боловсронгуй болгох гэж заасны</p>	<p>/-/</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаадын зээл тусламжид хамруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	дагуу газрын тосны борлуулалтын болон бусад орлогоос 2019 онд улсын төсөвт 335 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
9	11	Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай  2018-07-09 Дугаар 2018_220  3.. “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Шарын гол” ХК-уудын үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах хэмжээний дизелийн түлш, шатахууны нөөц бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийж, нүүрсний бэлэн нөөцийг хэвийн хэмжээнд байлгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай.	“Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Шарын гол” ХК-уудын үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах хэмжээний дизелийн түлш, шатахууны нөөц бүрдэлт хэвийн эсэхэд 2018 оны 08 дугаар сарын 24-ны өдөр УУХҮЯ-аас холбогдох үзлэг шалгалтыг хийж шатахууны нөөц бүрдүүлэлт, өвөлжилтийг бэлтгэлийг хангуулах арга хэмжээ авч ажиллав.	100  Өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулсан, тогтоолын хэрэгжилт хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
10	12	Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай  2018-10-24  Дугаар 2018_322 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компаний нөөцийг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул	Тогтоолын дагуу аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, газрын тосны бүтээгдэхүүний 2019 оны компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээнд анхаарч ажиллаж, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллах үүргийг 2018.11.27-ны өдрийн 07/3165 дугаар бүхий албан тоотоор АМГТГ-т хүргүүлсэн. АМГТГ нь 2019 онд нийт 26 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, нийт 116550 тонн газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхээр ажиллаж байна. 2019.01.09-ны өдрийн байдлаар улсын	30	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д. Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай.	хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 32 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 85, Аи-92 автобензин 29, дизелийн түлш 28, ТС-1 онгоцны түлш 22 хоногийн нөөцтэй байна.		
2.ё.Ерөнхий сайдын захирамж					
1	1	<p>Ажлын хэсэг байгуулах тухай /Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон газрын тосны бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах,</p> <p>2018-12-10</p> <p>Дугаар 2018_201 2.. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах асуудлаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллуулах, ажлын явцад хяналт тавьж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ө.Энхтүвшин)-т даалгасугай.</p>	<p>Захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох танилцуулгын хамт 2018.12.28-ны өдрийн 01/3502 тоот албан бичгээр Шадар сайдад хүргүүлсэн. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах дэд ажлын хэсэг байгуулахаар АМГТГ, холбогдох яам, агентлаг, байгууллагуудад албан тоот хүргүүлээд байна.</p>	30	
2.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1	1	<p>2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тэмдэглэлд</p> <p>2013-07-06</p> <p>2 XIII. 2. "Газрын тосны олборлолт, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайгаас Монгол, Хятадын хилийн Баянхошуу боомтын чиглэлд 210,7 км хатуу хучилттай авто зам барих ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож ажиллахыг Зам тээврийн сайд</p>	<p>Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210,7 км хатуу хучилттай авто замын 1 болон 2 дугаар хэсгийн барилгын ажлыг БНХАУ-ын Дачин зам, гүүрийн компаниар гүйцэтгүүлэн 2014 оны 12 дугаар сард байнгын ашиглалтад оруулж, 3 болон 4 дүгээр хэсгийн барилгын ажлыг Арж Капитал ХХК-иар гүйцэтгүүлэн, 4 дүгээр хэсгийг 2017 оны 12 дугаар сард, 3 дугаар хэсгийг 2018 оны 11 дүгээр сард тус тус гүйцэтгэж дууссан. Зам, Тээврийн Хөгжлийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 395 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж тус авто замыг 2018 оны 11 дүгээр сард байнгын ашиглалтад оруулсан.</p>	100	Тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар хэрэгжиж, авто зам бүрэн ашиглалтанд орсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

		А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт тус тус даалгав.			
2	2	<p>2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 12 дугаар тэмдэглэл</p> <p>2016-02-29</p> <p>ХҮ. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх явцад үүссэн зарчмын зөрүүтэй асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд үүрэг болгов.</p>	<p>2014.07.01-ний өдөр батлагдсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан БХГ-нүүдийн үндсэн нөхцлийг өөрчлөхгүйгээр ЗГ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх зорилго бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2018.01.17-нд А/12 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг гэрээлэгчидтэй харилцан зөвшилцөж хэлэлцээр хийсний үр дүнд саналын зөрүүтэй асуудлууд байсан хэдий ч хайгуулын гэрээнүүдийг шинэчлэх ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Уг асуудлыг УУХҮЯ-ны 2018.10.18-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дараах шийдвэрийг гаргуулсан. Үүнд:</p> <p>1. Хайгуулын үе шатанд хэрэгжиж буй Галба XI талбайн гэрээний тухайд хайгуулын ажлыг эрчимжүүлж, үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлж ЭБМЗ-өөр нөөцөө батлуулсны дараа БХГ-ний одоогийн нөхцлүүдийн дагуу эдийн засгийн үр ашигтай эсэх асуудлыг дахин ярилцах боломжтой. Иймд гэрээ шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх;</p> <p>2. Тариач XV талбайд байгуулсан БХГ-ний хэрэгжилтийг дүгнэж, гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар холбогдох шийдвэрийг гаргаж, үргэлжлүүлэх тохиолдолд БХГ-г яаралтай шинэчлэх;</p> <p>3. БХГ дуусгавар болсон Борзон VII, БХГ-г цуцлах талаар санал ирүүлсэн Төхөм X (хойд) Цагаан-элс XIII, Зүүнбаян XIV, Цайдам XXVI талбайд байгуулсан БХГ-нүүдийг дуусгавар болгож нээлттэй зарлах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж талбайнуудын хайгуулын ажлын доод хэмжээ, төлбөрийн</p>	<p>100</p> <p>ЗГ-ын 2018.05.02-ны, 2018.10.03-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	

			<p>асуудлыг шүүхээр нэхэмжлэн шийдвэрлүүлэх, талбайг буцаан авах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж арга хэмжээ авч ажиллах;</p> <p>4. Ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгчийн тавьж буй татварын асуудлуудыг Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах замаар гэрээний бус хуулийн хүрээнд шийдвэрлэх саналыг ЗГ-т уламжилж УИХ-аар шийдвэрлүүлэх;</p> <p>5. Ашиглалтын Тосон уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж буй Петровича дачин Тамсаг ХХК, БХГ-т 97 талбайд үйл ажиллагаа явуулж буй Доншен газрын тос (Монгол) ХХК-тай тус тус байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг шинэчлэх талаар зарчмын зөрүүтэй асуудлыг ЗГ-т танилцуулахаар бэлтгэл ажлыг хангах. БХГ-нүүдийг 2015 оны Засгийн газрын 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайд БХГ байгуулсан “Капкорп Монголиа” ХХК-ийн, Матад ХХ талбайд БХГ байгуулсан “Петро Матад” ХХК-ийн, Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн гэрээг тус тус шинэчлэн байгуулж эдгээр БХГ-үүдийн хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2018.05.02-ны, 2018.10.03-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан.</p>		
3	3	<p>2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 15 дугаар тэмдэглэл</p> <p>2016-03-14</p> <p>Ү. Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарын санаачлан боловсруулсан Шатахууны эрсдэлийн</p>	<p>УУХҮ-ийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг батлуулсан. Мөн төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар</p>	100	<p>Уг хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй болсон тул ХЯНАЛТААС</p>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хууль санаачлагчтай тохиролцсоны үндсэн дээр хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулах ажлыг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав.</p>	<p>баримтлах бодлого"-ыг боловсруулж, ЗГ-ын 2018.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 169 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шатахууны эрсдлийн сан, нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээнүүд тусгагдсан. Түүнчлэн Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, 2018.06.06, 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн мэдүүлсэн. Иймд шатахууны эрсдлийн нөөцтэй холбоотой асуудлыг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган шийдвэрлэх боломжтой тул тус хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй болсон.</p>	<p>ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
4	4	<p>2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл</p> <p>2017-03-29</p> <p>2 Нисэх онгоцны шинэ буудлыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд</p>	<p>Замын Үүд боомтод агаарын хөлгийн шатахууныг импортлох асуудлаар 2017 оны 02, 03 дугаар саруудад Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж /ШТШАБ/ ТӨҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын уулзалтуудыг хийж, уулзалт, хурлын шийдвэрийг гаргаж АМГТГ, ИНЕГ-ын даргын 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/265, а/59 дугаар хамтарсан тушаалаар ШТШАБ-ын өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах, хяналт тавих, батлуулах, хүлээн авах үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсэг зургийн даалгавар боловсруулахтай холбогдуулан Замын-Үүд суманд 2017 оны 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажилласан бөгөөд ШТШАБ-ийг өргөтгөхтэй холбоотойгоор газрын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай талаар дүгнэлтийг гарган, холбогдох хүсэлтийг аймгийн Засаг даргад</p>	<p>70</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав.	хүргүүлсэн. Үүний үр дүнд байгууламжийн өргөтгөлд шаардлагатай газрын хэмжээг нэмэгдүүлэх асуудал Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэж, тус хурлын 2017 оны 17 тоот тогтоолоор батлагдан, Дорноговь аймаг, Замын Үүд сумын Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/163 дугаар захирамжаар “ЗҮ-ШТШАБ” ТӨҮГ-т 1 га газрыг 15 жилийн хугацаатай шинээр нэмж олгох шийдвэрийг гаргуулсан. Түүнчлэн Ажлын хэсэг нэмж шинээр өргөтгөх хэсгийн сав, насос станц, технологийн шугам хоолой барих газрыг урьдчилсан байдлаар төлөвлөн, зургийн даалгавар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн батлуулав. Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх зураг төслийг боловсруулж дуусан, шаардлагатай төсвийг хийж гүйцэтгэв.		
5	5	2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл  2017-10-20  6. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2018 оны 1 дүгээр сард багтаан бүрдүүлэх арга хэмжээ авч, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг ханган нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АМГТГ нь газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгжтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг 2018.01.25-ны өдөр байгуулсан. 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх 21 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг агуулахын байршлуудаар нь нэгтгэн Төв, Баруун, Зүүн гэсэн 3 бүст хуваан хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн эхний сарын нөөцийг 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авсан. Улсын хэмжээнд 2018 онд газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг сар бүр дунджаар 30 хоногийн нөөцийг бүрдүүлэн ажилласан. 2018 онд Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж тасралтгүй, нөөц хэвийн байлаа.	100	Компаний нөөцийг хэвийн бүрдүүлж ажилласан, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг бүрэн хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ
6	6	2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 18 дугаар тэмдэглэл	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 108 тоот тогтоолоор 1."Газрын тосны хайгуулын "Эргэл-12" талбайд		

	<p>2018-04-25 №: 2018_18</p> <p>Х.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Газрын тосны хайгуулын болон ашиглалтын чиглэлээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Сумъяабазарт даалгав.</p>	<p>газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны газар, "Смарт ойл инвестмент ЛТД" компанийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх үүргийг "Смарт петролиум инвестмент ЛТД" компанид бүхэлд нь шилжүүлсүгэй. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг зохих хууль тогтоомжид заасны дагуу кохион байгуулахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд даалгасугай. гэсэн тогтоолыг гаргуулсан.</p>	<p>100</p> <p>ЗГ-ын хуралдаанд танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
7	<p>2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 20 дугаар тэмдэглэл</p> <p>2018-05-02</p> <p>Дугаар 2018_20 2.. Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагааг бодлогын удирдамжаар ханган хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус үүрэг болгов.</p>	<p>Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагааг бодлогын удирдамжаар ханган хяналт тавьж ажиллаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газарт чиглэл өгч ажиллаж байна. Өвөрхангай, Баянхонгор аймгийн зарим сумдад газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар, төр, засгаас гаргасан тогтоол, шийдвэрийн талаар УУХҮЯам болон АМГТГ-тай хамтаран орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч ажилласан.</p>	<p>30</p>	
8	<p>ХХII.9. 2. . Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.</p>	<p>Энэхүү тэмдэглэлийн мөрөөр "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд гүйцэтгэгч компаниудаас долоо хоног бүр тайлан гаргуулан авч хяналт тавин ажиллаж байна. Мөн УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар "Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн</p>	<p>100</p>	

			үндэслэлийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдөр хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн.		
	9	<p>XXII.9. 3. . Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав.</p>	<p>Энэхүү тэмдэглэлийн мөрөөр "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар "Зээлийн гэрээ"-г тус тус байгуулан ажиллаж байна. Энэхүү зээлийн хөрөнгөөр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэлийн дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын байдлаар энэхүү төслүүдэд "Хөгжлийн банк"-наас нийт 20 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.</p>	100	
8	10	<p>2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл</p> <p>2018-07-04 Дугаар 2018_29</p> <p>XIY.. Газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны газар (хуучин нэрээр) болон “Магнай трейд” ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг “Магнай трейд” ХХК-аас “Эм Ти ПЛО” ХХК-д бүхэлд нь шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс</p>	<p>Газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Магнай трейд” ХХК-аас “Эм Ти ПЛО” ХХК-д бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг бүхэлд нь шилжүүлэх талаарх танилцуулгыг мөн бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулалгүй тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой саналыг боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахтай холбоотой мэдээлэл, танилцуулга, холбогдох шийдвэрийн төслийн хамт яаманд ирүүлэх тухай УУХҮСайдын 2018.08.30-ны өдрийн 01/2292 тоот албан бичгийн АМГТГ-т хүргүүлсэн. Үүний дагуу АМГТГ-аас ирүүлсэн холбогдох танилцуулга материалыг судлан Засгийн газрын 2018.10.03-</p>	70	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>чиглэл авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулалгүй тусгай зөвшөөрөл (гэрчилгээ)-ийг бусдад шилжүүлж (худалдаж) байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>ний өдрийн хуралдаанаар асуудлыг танилцуулан 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан болно.</p>		
9	11	<p>2018 оны 8 дугаар сарын 2-ны өдөр 32 дугаар тэмдэглэл</p> <p>2018-08-02 Дугаар 2018_32</p> <p>ХҮҮ.3. . Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Сангийн яам холбогдох бусад байгууллагатай хамтран газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах чиглэлээр Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын дараагийн хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>2018.08.15-ны ЗГ-ын хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай асуудлыг дахин хэлэлцүүлсэн. Тус хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд уг асуудлаар тодорхой санал боловсруулан хэлэлцүүлэхийг МУ-ын Шадар сайд Ө.Энхтүвшинд даалгасан. 2018.10.03.-ны өдрийн ЗГ-ын хуралдааны 20 дахь асуудал Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган төслийг дахин хэлэлцэхээр хойшлуулж, гэсэн 41 дүгээр тэмдэглэлийг гаргасан. Дээрх удаа дараагийн хуралдаануудаар газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгыг боловсруулж, хэлэлцүүлсэн.</p>	100	Өгөгдсөн үүргийн дагуу асуудлыг дахин хэлэлцүүлж тэмдэглэл гаргуулж холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ
10	12	<p>2018 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл</p>	<p>1. УУХҮС-ын 2018.12.12-ны өдрийн 01/3306 тоот албан бичгээр “дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр</p>	30	

		<p>2018-10-03</p> <p>Дугаар 2018_41 ХХIII.6. . Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу холбогдох байгууллагуудтай хамтарсан шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд 2019 оны 3 дугаар сард танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p> <p>2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгов.” гэжээ.</p>	<p>барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах” талаар агентлаг төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр яаманд мэдээлж байхыг мэдэгдээд байна. 2. БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ-ын төлөөлөл бүхий Ажлын хэсгийг УУХҮС-ын 2018.12.03-ны өдрийн А/250 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.</p>		
<u>Хэсгийн дундаж: 81.3 хувь</u>					
<b>Салбар чиглэл: 3 – УУЛ УУРХАЙН БОДЛОГО</b>					
<b>3.а.Монгол Улсын хууль</b>					
1	1	<p>ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга) 2013-01-31</p> <p>10.1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутагт дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Ажлын хэсгийн хүрээнд дүрмийг</p>	70	

		<p>төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална.</p>	<p>төслийг боловсруулахаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Багануур” ХК, “Оюутолгой” ХХК-ийн үйлдвэрлэлийн баазыг түшиглэн ажлын хэсэг вакум орчинд ажиллан дүрмийн төслийг боловсруулсан. Мөн “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан ёсны вэб сайт <a href="http://mmhi.gov.mn/public/forum/id/639">http://mmhi.gov.mn/public/forum/id/639</a>-д олон нийтийн санал авахаар байршуулсан ба төслийн хэлэлцүүлгийг Тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой хамтран 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн захиргааны V байрны ХАБ Инновацийн төвийн хурлын танхимд 45 орчим оролцогчтойгоор зохион байгуулсан. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулсан. Мөн дүрмийн төслийн танилцуулга болон нөлөөллийн шинжилгээний тайланг боловсруулсан. /Биелэлт-90%/</p>		
2	2	<p>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2015-02-18</p> <p>47.2 Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.</p>	<p>“Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл</p>	70	

		<p>ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия” ХХК-иас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Орд ашиглах гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголия” ХХК-иас Гацууртын ордын нөөцийн тодотгол, техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг батлуулах, тус ордыг ашиглах эсэхийг шийдвэрлэхтэй холбоотойгоор уг асуудал хүлээгдэж байна. Ашигт малматлын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нараар батлуулан Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан, Эдийн Засгийн байнгын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн хуралдаан, Улсын Их хурлын 2018 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн.</p> <p>Хуулийн төсөл батлагдсанаар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар ашигт малтмалын нөөц</p>		
--	--	--	--	--

			ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх боломж бүрдэх юм. /Биелэлт 90%/		
3.б.Улсын Их Хурлын тогтоол					
1	1	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай 2010-07-07  1.2.б б/хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;	2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуй нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуй нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалсаны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн. Засгийн газрын 2017 оны 154 дугаар "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна. "Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолоор тус ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад,	70	

			<p>дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ, ЗГ-аас "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг олон улсын зах зээлд IPO гаргах үүргийг өгснөөс хойш ордыг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулж, дэд бүтцийн төслүүдийн тооцоо, судалгааг хийх ажлуудыг зохион байгуулаад байна.</p> <p>/Биелэлт-90%/</p>		
2		<p>Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай 2010-07-07</p> <p>1.2.в хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;</p>	<p>Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон.</p> <p>Харин Засгийн газрын 2016 оны 316 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд дээрх хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>"Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан, Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, Улсын Их хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн</p>	70	

			<p>73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Оюутолгой-Ханги, Тавантолгой-Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам болон Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. /Биелэлт 80%/</p>		
2	3	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-02-07</p> <p>1.11 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн барилга, уул уурхай, эрчим хүч, зам, тээвэр, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажил олгогч, ажилтанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулдаг болох, үүнтэй холбогдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах;</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн 3 талт үндэсний хорооны салбар нэгж болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн А/48 тоот тушаалаар байгуулан салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлогыг томъёолох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн ХНХЯ болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж, Уул уурхайн салбарын аж ахуй нэгж, ажилчдад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, ажил хийгдэж байна. Тухайлбал салбар хорооноос НЭН ТҮРҮҮНД ХАБ-2017 үндэсний бага хурлыг</p>	<p>100</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын асуудал болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн асуудал нь Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудал тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

			<p>зохион байгуулах удирдах хороонд ажиллаж, 2017 оны 3-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулж, Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангаж ажилласан.</p> <p>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2018 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ХАБЭА-н дэд хөтөлбөр боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Тус дэд хөтөлбөрт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх талаар тусгахаар ажиллаж байна.</p>		
3.в.УИХ-ын байнгын хорооны тогтоол					
1	1	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2011-01-19</p> <p>II.1.1 МУ-ын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолын 3 дахь заалтын биелэлтийг хангах, АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай</p> <p>Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийж шийдвэрлэх</p>	<p>2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн Газар (Эрдэнэс Оюу Толгой ХХК) болон Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон Оюу Толгой ХХК-ийн хооронд Оюу толгой төслийн 2 дахь шат буюу Далд Уурхайн Бүтээн байгуулалтын, санхүүжилтийн гэрээг байгуулсан. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил хэвийн явагдаж байна.</p>	70	
2	2	<p>Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015-04-08 №10</p> <p>1.1 УИХ-ын 2010 оны 39, 2012 оны 18</p>	<p>Тогтоолын дагуу эзэмшлийн бүртгэлийг баталгаажуулах зорилгоор Засгийн газрын ХЭГ, Сангийн яам, Уул уурхайн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Эрдэнэс Монгол” ХХК, “Үнэт</p>	100	Тогтоол бүрэн хэрэгжсэн тул

		дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах шуурхай арга хэмжээ авч, "Эрдэнэс тавантолгой" хувьцаат компаний хувьцааны эзэмшлийн бүртгэлийг баталгаажуулах ажлыг 2015 онд багтаан хэрэгжүүлэх	цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, "Улсын бүртгэлийн ерөнхий газар", "Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар", "Нийгмийн даатгалын ерөнхий газар", ЭТТ ХК-ийн төлөөлөл оролцсон ажлын хэсгийг байгуулж ажилласан боловч нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй. Иймд Засгийн газрын ХЭГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 283 дугаар тушаалаар 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж "Эрдэнэс тавантолгой"ХК-ийн хувьцааны эзэмшлийн бүртгэлийг бүрэн хийж дуусгаад байна.	ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
3	3	1.5 Засгийн газарт болон "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс монгол" ХХК-д Эдийн Засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Тавантолгойн Цанхийн Зүүн уурхайн гэрээт олборлолтын ажлын хөлс болон нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлж барагдуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот /2015.04.28-ны 1/1004/-ыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн. "Эрдэнэс-Тавантолгой" ХК нийт 45.8 сая тонн нүүрс олборлож, 4.6 их наяд төгрөг буюу 2.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаас 2017, 2018 онд 3.1 их наяд төгрөг, үүнээс 2018 онд 1.99 их наяд төгрөгийн орлоготойгоор 2010 оноос хойш үүссэн гадаад, дотоод өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан. 2018 онд улсын төсөвт 510 тэрбум төгрөг төвлөрүүлж, компанийн цэвэр ашгийг 720 тэрбум төгрөгт хүргэсэн. 2016 оны 1-р улиралд Чалко компанид нэг тонн нүүрсийг 24.97 ам.доллар нийлүүлж байсан бол 2017 оны 1-р улиралд 59.33 ам.доллар, 2018 оны 2-р улиралд 61.0 ам.доллар, 2019 оны 1-р улирлаас 63.32 ам.доллар болгож нэмэгдүүлснээр үнийг 2.5	100	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

			дахин өсгөсөн. Цанхийн баруун уурхайн 2016 оны 1-р улиралд 23.2 ам.доллар байсан үнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар 71.25 ам.доллар болгон нэмэгдүүлж, коксжих нүүрсний 20 гэрээ, исэлдсэн нүүрсний 7 гэрээг тус тус байгуулсан нь өндөр үр ашигтай ажиллах суурь нөхцөлийг бүрдүүлээд байна.		
4	4	Чиглэл өгөх тухай 2015-05-29  3 Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах	"Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж Уул уурхай сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 229/А/232 дугаар хамтарсан тушаалаар батлуулж мөрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг олон улсын стандарт шаардлагад нийцсэн дүрмийн дагуу явуулах боломж бүрдсэн. Мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна.	70	
5	5	Чиглэл өгөх тухай 2015-05-29  4 Оюу толгой ордыг ашиглахад Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг гуйвуулалтгүй мөрдүүлэх, цаашид Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах	Оюу толгойн ордыг ашиглах талаар холбогдох хууль (Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хууль гэх мэт) , тогтоомж ("Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" УИХ-ын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоол), дүрэм (Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм), журмыг (Төрийн болон орон нутгын өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай) мөрдүүлж, бараа, ажил, үйлчилгээг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна. Мөн УИХ-аас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд "Оюутолгой" ХХК болон Оюутолгой төслийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байна. /Биелэлт-90 %/	100	

3.г.Ерөнхийлөгчийн зарлиг						
		<p>нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэж, паркад байгуулах паркийн нэгжүүд, тэдгээрийг байгуулах аж ахуйн нэгж, нийт хөрөнгө оруулалт, түүний үндэслэл тооцоо, судалгааг эцэслэн гаргуулж, "Шинэ Азиа групп" ХХК-тай хамтран Засгийн газрын хуралдаанд 2015 оны 1 дүгээр сард багтаан танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид даалгасугай.</p>	<p>төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгээгүй, паркийн үйл ажиллагааг эхлүүлээгүй өдийг хүрсэн. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болон дууссан.</p>	<p>ХАСУУЛАХ САНАЛТАЙ /</p>	
2	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай</p> <p>2014-10-25 352</p> <p>3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл авснаас хойш тодорхой хугацааны дараа техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын үндэслэл, судалгаа зэрэг хуульд заасан шаардлагыг танилцуулсны үндсэн дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх тухай үүрэг хүлээлгэх журмыг эрх зүйн үндэслэлийн хамт боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид үүрэг болгосугай.</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлагыг тодорхой заасан байдаг. Гэтэл Засгийн газрын 352 дугаар тогтоолын заалт нь хуулийн дээрх заалттай зөрчилдөж байгаа болно. Энэ талаар Хууль зүйн яамнаас амаар тодруулга авсан бөгөөд үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр журмаар зохицуулах боломжгүй гэсэн тайлбар өгсөн. УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох сайд нараар батлуулсан. Мөн хуулийн төслийн талаар бүх яамдаас санал авч нэгтгэсэн ба Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.</p>	<p>/-/</p> <p>Хуулийн заалттай зөрчилдөж байгаа тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>		
2	3	<p>Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай</p> <p>2017-02-15 №59</p> <p>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банкт хэлэлцэн тохиролцохыг Сангийн сайд</p>	<p>ТӨБЗГ-ын 2017 оны 4-р сарын 4-ни өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" компанийг байгуулан ажиллаж байна. БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд</p>	<p>100</p> <p>ХЭРЭГЖСЭН. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	

		<p>Б.Чойжилсүрэнд, төслийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж болон холбогдох сайд нарт даалгасугай.</p>	<p>"Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ний Б/208 тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017 оны 06 дугаар сарын 06-ний өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай эхний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл болон холбогдох асуудлуудаар хэлэлцээр хийж байна.</p> <p>Улмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэхтхэг Улсын Экспорт-импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн зориулалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын байнгын хороодоор зөвшилцсөний дараа ажлын журмаар Засгийн газрын зүгээс шийдвэр гаргахаар ЗГ тэмдэглэл гарсан. ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна.</p>		
3	4	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай</p> <p>2017-03-15 №: 2017_88</p>	<p>УУХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна.</p>	30	

		<p>2 Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай.</p>	<p>Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компаниар "Таван Лекс" ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан.</p> <p>Төслийн явцыг талаар Ерөнхий сайдын ажлын албанд 2017 оны 12 дугаар сарын 16-ны өдөр танилцуулсан. Мөн Үндэсний хэмжээний төсөл болох "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авч байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл, цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх тухай саналыг 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/2889 тоот албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. Мөн 2019 оны 01 дүгээр сард Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн талаар танилцуулга хийсэн.</p>		
	5	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2017-03-15 №: 2017_88</p> <p>3 Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.</p>	<p>Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулаагүй байгаа</p>	<p>/-/</p> <p>ХЭРЭГЖИХ ХУГАЦАА НЬ БОЛООГҮЙ БАЙНА.</p>	
4	6	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай /Хөгжлийн зам/ 2017-05-10 №: 2017_142</p> <p>3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг</p>	<p>Хөтөлбөрийн 3.7.3 Багануурын нүүрсний ордыг түшиглэн нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн барилгын ажлыг дуусгах, 3.7.4 Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн</p>	<p>100</p> <p>Хөтөлбөрт тусгагдсан</p>	

		эрхэлсэн салбартаа хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг 2017-2021 онд дуусгах заалтын хүрээнд тус төслүүдийн үйл ажиллагааг хангах Төслийн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган ажиллаж байна.	зорилтын хэрэгжилтийг хангах хугацаа болоогүй, тул хяналтаас хасуулах саналтай.	
5	7	<b>Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай</b> <b>2017-08-17</b> <b>№232</b> 1. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай.	Хөтөлбөрийн 3.7.1. " Хэрлэн тооно" төслийг хэрэгжүүлэх, хүнд үйлдвэрүүдийн үйл ажиллагааны усны хэрэгцээг хангах урсацын тохируулга бүхий усан цогцолбор байгуулах" заалтын хүрээнд "Төслийн техникийн даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулах зорилго бүхий хоёр яам /БОАЖЯ/-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл”-ийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2020 тоот албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтыг 2018 онд зохион байгуулах ажлын үндсэн хариуцагчаар БОАЖЯ ажиллаж байгаа болно.	70	
6	8	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай  2017-08-23 №: 2017_242  2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулж, хууль тогтоомж болон гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай.	Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 242 дугаар тогтоолоор паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон "Дархан үйлдвэрлэл, технологийн парк" ХХК, "Эрдэнэт технопарк" ХХК-д УУХҮ-ийн сайдын 2017 оны А/200 дугаар тушаалаар паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. Мөн УУХҮЯ нь тус паркийн удирдлагуудтай 2017.10.09-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд паркийн удирдлагууд гэрээний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2017.11.30-ны өдөр тус паркийн удирдлагууд УУХҮ-ийн сайд Б.Сумъяабазарт	100  ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОСОН, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭЖ АЖИЛЛАЖ БАЙГАА, ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	

			гэрээний дагуу хийж хэрэгжүүлж байгаа ажлынхаа талаар тайлагнав. Паркийн удирдлагын УУХҮЯ-тай байгуулсан гэрээний биелэлтийн 2018 оны тайланг авч, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав..		
7	9	<p>Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2018-01-03 №2</p> <p>3. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт /төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай/-ын ажлыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнгийн талаар Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг УУХҮС Д.Сумъяабазар... нарт тус тус даалгав.</p>	<p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолоор үйлдвэр байгуулахад шаардагдах гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18,2 км урттай 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16,6 км урттай хатуу хучилттай авто зам барих төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтын ажлыг тухайн ажлыг гүйцэтгэх туршлага, техник тоног төхөөрөмжийн чадавхтай төрийн өмчит хуулийн этгээдүүдээс сонгон хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд нарт даалгасан.</p> <p>Түүнчлэн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах санхүүжилтийг Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Одоогоор Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 17,5 км урт автозамын барилга угсралтын ажил 40%, цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил 90%, салаа төмөр замын ажил 40%-ийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний</p>	100	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай

			тухай” 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсний дагуу яамны зүгээс “газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин, ЗГ-ын хуралдаанд тухай бүр танилцуулан ажиллаж байна. Дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийн барилга угсралтын ажлуудыг 2019 оны IV улиралд багтаан гүйцэтгэж ашилалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.		
8	10	<p>Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлах тухай 2018-01-31 №: 2018_36</p> <p>2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг 2 үе шаттайгаар (I үе шат 2018–2019 он, II үе шат 2020 – 2021 он) хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн төслийг ХХААХҮЯ-наас боловсруулж яамдаас санал авах үед УУХҮЯ-наас хүнд үйлдвэрийн чиглэлийн үйлдвэрүүдийн талаарх заалтуудыг хасах санал оруулж, тус яамны хамаарал бүхий үйлдвэрүүд жагсаалтаас хасагдсан.</p>	/-/	<p>УУХҮЯ-НД ХАМААРАХГҮЙ ТУЛ ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ</p>
9	11	<p>“Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлах тухай 2018-02-06 №: 2018_42</p> <p>3. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын</p>	<p>Зорилт 4-ийн хүрээнд: “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолын дагуу Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”,</p>	70	

	<p>хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар тус тус даалгасугай.</p> <p>2.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт:</p> <p>Зорилт 4. Монгол Улсын эдийн засгийн өндөр өсөлтийг хангах уул уурхайг хөгжүүлж, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулан иргэдэд ногдол ашиг хуваарилах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>Зорилт 5. хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх;</p> <p>Зорилт 6. уул уурхайн хөгжлийг дэмжих тээвэр, дэд бүтцийг барьж байгуулах.</p>	<p>“В”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.</p> <p>Зорилт 5-ын хүрээнд: Засгийн газраас 2017 оны 2-р сарын 17-ны “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай” 59 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>-ТӨБЗГ-ын 2017 оны 4-р сарын 4-ний өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийг байгуулан ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг эхлүүлж, Зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг 2017.02-08 дугаар сарын хооронд Энэтхэг Улсын Эксим банктай хамтран зохион байгуулсан. Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Энэтхэгийн “Инженерс индиа лимитед” компани шалгарч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2017.08.09-ний өдөр байгуулсан. Захиалагч Уул уурхай, хүнд</p>		
--	--	---	--	--

		<p>үйлдвэрийн яам, төсөл хэрэгжүүлэгч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК компани болон захиалагчийн инженер Итали Улсын "КТ-Кинетикс" компанийн зүгээс нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018.11.15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт гаргуулж, хүлээн авахаар шийдвэрлэсэн. Зорилт 6-ын хүрээнд: "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах санхүүжилтийг Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Улмаар Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 17,5 км урт автозамын барилга угсралтын ажил 40%, цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил 90%, салаа төмөр замын ажил 40%-ийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 323 дугаар тогтоолоор "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсний дагуу яамны зүгээс "газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийн барилга угсралтын ажлуудыг 2019 оны IV улиралд багтаан гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>		
--	--	---	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

10	12	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-10-24 Дугаар 2018_323 2.. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу баталж, мөрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн А/259 дугаар тушаалаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчлэн баталсан.	100  Бүрэн хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ	
	13	3.. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай.	Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Дорнод аймгийн Матад сум, Дорноговь аймгийн Зүүнбаян сумын нутаг дэвсгэрт Тосон-Уул XIX, Тамсаг- XXI, БХГ-97 газрын тосны олборлолтын талбайд үйл ажиллагаа явуулж байгаа БНХАУ-ын "Петрочайна Дачин тамсаг" ХХК, "Доншен Газрын Тос Монгол" ХХК-ийн удирдлагуудтай Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны асуудал эрхэлсэн орлогч дарга 2018 оны 09 дүгээр сарын 17-ний өдөр уулзалт зохион байгуулж Монгол Улсад байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах асуудлаар санал солилцсон. Уг уулзалтаар Монгол Улсад олборлож буй газрын тосыг Монгол Улсын Газрын тосны тухай хуульд заасны дагуу олборлолт явуулж буй компанийн зүгээс олон улсын жишиг үнээр тооцон нийлүүлэх боломжтой тухай мэдэгдсэн.	70	
	14	4.. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн шийдлийг сонгох, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар БНЭУ-ын ИИЛ (Engineers India Limited) компаний боловсруулсан ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн 2018 оны 11 дүгээр сард хүлээн аваад байна. Тус ТЭЗҮ-д төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг 1.236 тэрбум ам.доллар байхаар тооцоо гарсан бөгөөд нэмэлт санхүүжилтийг БНЭУ-ын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шийдвэрлэх хүсэлтийг урьдчилсан байдлаар холбогдох	30	

		талуудад хүргүүлсэн. Төслийн түүхий тос дамжуулах хоолойн технологийг судлах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх түүний бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тодорхойлох чиглэлээр бусад хөгжлийн түнш, талуудтай ажлын түвшинд хэлэлцэж байна.		
15	5.. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж, төслийн үе шатны ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БНЭУ-ын Эксим банкнаас 2018 оны 10 дугаар сард “Монгол Улсад хэрэгжих газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн төслийн менежментийн зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг хоёр улсын хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд зарлаж, тус тендерт Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитед” компани дангаараа санал ирүүлж, сонгон шалгаруулалтад тэнцсэн тухай 2018.12.04-ний өдрийн “GOILOC-258/18-19/2107” дугаар албан бичгээр мэдэгдсэн. Дээрх урьдчилсан сонгон шалгаруулалтад нэг компани санал ирүүлж тэнцсэн нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7-д “Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс энэ хүүлийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас заасан чадавхийн үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож хураангуй жагсаалт гаргана”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “Тендерт оролцогч нь бараа, ажил үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдэд нэгдмэл сонирхолтой бол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ” гэж заасантай зөрчилдөж байгаа тул Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах боломжгүй болсон тул зөвлөхийг	30	

			сонгох асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Энэтхэгийн талтай санал солилцохоор 2018.12.17-ны өдөр албан бичгийг БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Эксим банкинд хүргүүлээд байна.		
16	6.. Үйлдвэрийн байршил хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, төсөл хэрэгжүүлэгч компанийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасгай.		Одоогоор Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 17,5 км урт автозамын барилга угсралтын ажил 40%, цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110/10 кВ-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил 90%, салаа төмөр замын ажил 40%-ийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсний дагуу яамны зүгээс “газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийн барилга угсралтын ажлуудыг 2019 оны IV улиралд багтаан гүйцэтгэж ашилалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	70	
4.ё.Ерөнхий сайдын захирамж					
1	1	Ажлын хэсэг байгуулах тухай “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах  2016-11-22 №: 2016_113  2 Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг	Засгийн газрын 2016 оны 107 дугаар тогтоолынхэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулан ажиллаж байна. Монгол улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 113 тоот захирамжаар байгуулагдсан “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах” төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах	70	

		<p>2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай.</p>	<p>үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг УУХҮЯ-ны хурлын танхимд 2017 оны 01 дүгээр сарын 25 өдрийн 11 цагт Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Баатарсүх даргалан явуулсан. Энэхүү хуралдаанаар төслийн нэгжийн танилцуулга хийгдэн дараах асуудлуудыг шийдвэрлэхээр болсон.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ЭХЯамны түгээх шугам сүлжээний журам, стандартаа гаргах ажлын хэсэгт ХҮБГ-аас мэргэжилтэн ажиллуулах</li> <li>2. БОАЖЯам, ННБХҮ үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ний хүрээнд хийгдсэн байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээнд холбогдолтой дүгнэлтийг гаргах.</li> <li>3. Төслийн нэгж, “Эрдэнэс Монгол”ХХК болон Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, судалгааг хийх, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, Багануурын уурхайн удирдлага мэргэжилтнүүдэд төслөө танилцуулах.</li> <li>4. Төслийн нэгж, Төв аймгийн Баяндэлгэр суманд төслийн байршлын газрын асуудлаар 2017 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн дотор аймгийн удирдлагуудтай хамтран ажиллах.</li> </ol> <p>-“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ГОСТ болон ISO-ийн 20 гаруй стандартыг орчуулан MNS стандарт болгон батлуулахаар ажиллаж байна.</p> <p>-“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхөөр шалгарсан БНХАУ-ын "Wuhuan engineering" компани төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж 2017 оны 5 дугаар сард УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн бол БОННҮ-ний зөвлөх “Green trends” ХХК нь БОННҮ-ний эхлэлийн тайланг 2018 оны 7 дугаар сарын 05-ны өдөр ирүүлээд байна.</p> <p>Төслийн БОННҮ-ний эцсийн тайланг боловсруулж байгаа бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгийн ажлыг зохион байгуулан эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>- Төв аймгийн Баяндэлгэр сумын иргэдийн</p>		
--	--	---	--	--	--

			<p>төлөөлөгчдийн 2017 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн хурлын 06 дугаар тогтоолоор Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн үйлдвэр баригдах газрыг “Сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө”-нд оруулан баталж, газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн. Мөн Төв аймгийн ИТХ-аас Хийг дамжуулах шугам хоолойн трассын байршлыг нарийвчлан тогтоож, хий дамжуулах хоолой дайран өнгөрөх газрыг тусгай хэрэгцээнд авах ажлыг дэмжих тухай 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоол гарсан.</p> <p>- Тус төслийн хөрөнгө оруулалт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бүс нутаг олон улсын хэмжээний чуулга уулзалт, арга хэмжээнд тогтмол оролцож төслийг танилцуулан ажиллаж байгаа бөгөөд БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпорац (CNPC)-ийн охин компани болох “Хуан Чү барилга угсралт, инженеринг” компани (HQC), “Хятадын газрын тосны шугам хоолой” компани (CPP), Хятадын Үндэсний химийн инженеринг корпораци, “Хятадын машин, механизм тоног төхөөрөмж инженеринг” ХХК, Дэлхийн банкны дэргэдэх Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн холбогдох албаны хүмүүстэй уулзаж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж байна.</p>		
2	2	<p>Ажлын хэсэг байгуулах тухай “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах</p> <p>2016-11-22 Дугаар 2016_114</p> <p>2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор</p>	<p>УУХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компаниар “Таван Лекс” ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан.</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг</p>	70	

		Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай.	хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018.08-10 сард зохион байгуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг “Өмгөөллийн Монгол өмгөөлөгч” ХХН-тэй байгуулсан бөгөөд явцын тайланг хүлээн аваад байна. Улмаар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцох юм.		
4.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1	1	2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2016-03-28 I Дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдаанаас учирч болох хохирлоос хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг Хууль зүйн сайдтай хамтран баталж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан хуулийн төслийн нэрийг оновчтой болгох зэрэг саналыг тусган хуулийн төслийг боловсруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав.	Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулиар гадаад худалдааны асуудал ГХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн.;	-/-	УУХҮЯ-НД ХАМААРАХГҮЙ БАЙХ ТУЛ ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ
2	2	2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2016-04-18 “Хөшигийн хөндий чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд үзэл баримтлалыг батлахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар зохих	Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулиар чөлөөт бүсийн асуудал Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн.	-/-	УУХҮЯ-НД ХАМААРАХГҮЙ БАЙХ ТУЛ ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		журмын дагуу хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгав.			
3	3	<p>2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 29 дүгээр тэмдэглэл 2016-05-23</p> <p>XXXI.3. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган уг асуудлаар тогтоолын төсөл боловсруулж, зохих журмын дагуу холбогдох байгууллагаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав.</p>	<p>УУХҮ-ийн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компаниар "Таван Лекс" ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан.</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018.08-10 сард зохион байгуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг “Өмгөөллийн Монгол өмгөөлөгч” ХХН-тэй байгуулсан бөгөөд явцын тайланг хүлээн аваад байна. Улмаар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцох юм.</p>	70	
4	4	<p>2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 36 дугаар тэмдэглэл</p> <p>2015-06-15 №: 2015_36</p> <p>ХХҮI.2. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр, цех байгуулах талаар өмнө нь гаргасан шийдвэрүүдийг өөрчлөх болсон шалтгаан, үйлдвэрийн байршлыг шинэчлэн тогтоосны ач</p>	<p>Аж үйлдвэрийн яам /хуучнаар/-аас Засгийн газрын 2015 оны “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 247 дугаар тогтоол батлуулж, үйлдвэрийг Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байгуулахаар байршилыг тогтоосон. “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2015 оны 247 дугаар тогтоол, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих тухай”</p>	/-/	<p>Засгийн газрын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар</p>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		холбогдлыг нийтэд сурталчлан танилцуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав.	Засгийн газрын 2016 оны 75 дугаар тогтоолын хэрэгжилтыг эрчимжүүлэх, нутгийн удирдлагууд, иргэдийн төлөөлөлд төслийн ач холбогдлыг танилцуулах, хамтран ажиллах зорилгоор Аж үйлддвэрийн сайд Д.Эрдэнэбат тэргүүтэй ажлын хэсэг Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд зөвлөлдөх, таниулах уулзалтыг 2016 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд зохион байгуулсан. Засгийн газрын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул хяналтаас хасах саналтай	тогтоолоор хүчингүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ	
5	5	2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2018-03-27 №: 2018_15 XXIX.14. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудалтай холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоог гаргасны үндсэн дээр аж ахуйн нэгж байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хүрээнд Монголбанк болон яамдын саналыг авч, Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	Холбогдох судалгааны ажлуудыг хийж "Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Монголбанк болон яамдын саналыг авч ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах үүрэг бүхий төрийн 100 %-ийн өмчит "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харьяанд байгуулан ажиллаж байна.	70	

6	6	<p>2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр 25 дугаар тэмдэглэл</p> <p>2018-06-06 Дугаар 2018_25</p> <p>ХҮ1.3. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн сонголт болон бусад асуудлаар Энэтхэгийн талтай хэлэлцэн эцэслэн тохиролцож, дүнг Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар БНЭУ-ын ИИЛ (Engineers India Limited) компаний боловсруулсан ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн 2018 оны 11 дүгээр сард хүлээн аваад байна. Тус ТЭЗҮ-д төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг 1.236 тэрбум ам.доллар байхаар тооцоо гарсан бөгөөд нэмэлт санхүүжилтийг БНЭУ-ын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шийдвэрлэх хүсэлтийг урьдчилсан байдлаар холбогдох талуудад хүргүүлсэн. Төслийн түүхий тос дамжуулах хоолойн технологийг судлах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх түүний бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тодорхойлох чиглэлээр бусад хөгжлийн түнш, талуудтай ажлын түвшинд хэлэлцэж байна.</p>	30	
	7	<p>XIX.10. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>10.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>Төслийн ТЭЗҮ бэлэн болсонтой холбогдуулан үйлдвэрийн технологийн сонголт, төсөвт өртгийн тооцоолол зэрэг хэд хэдэн асуудлуудаар Захиалагчийн зүгээс энэхүү төслийг хариуцан ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөгчид оролцсон техникийн зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2018 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулж, Монголын талаас УУХҮСайд Энэтхэгийн талаас Энэтхэгийн Гадаад хэргийн яамны хамтарсан нарийн бичгийн дарга ноён Прашант Агравал нар даргалан явууллаа. Энэхүү уулзалтаар төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд тусгагдсан “технологийн процесс, төслийн төсөвт өртгийн тооцоолол болон түүнийг хэрхэн бууруулах, төслийн менежментийн зөвлөхийг сонгон шалгаруулах, төслийн арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө, боловсруулах үйлдвэрт мэргэжилтэн бэлтгэх, төслийн менежментийн зөвлөхийн</p>	30	

			төлөөлөгчийн газрыг Улаанбаатар хотод байгуулах, нарийвчилсан ТЭЗҮ-г хүлээн авах” зэрэг хэд хэдэн асуудлыг хэлэлцэж талууд тодорхой тохиролцоонд хүрсэн.		
8	XIX.10..2. . Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.	Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УУХҮСайд 2018 оны 9 дүгээр сарын 23-наас 25-ны өдрүүдэд ОХУ-д албан айлчлал хийж "Роснефть" компанийн гүйцэтгэх захирал И.И.Сечинтэй уулзаж Төрөөс Газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлон хамтран ажиллаж байна. Мөн энэхүү уулзалтаар Монгол Улсад "газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн төсөл"-ийг МУ-ын Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж байгаатай холбогдуулан түүхий тос дамжуулах хоолойн технологийг судлах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх түүний бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тодорхойлох чиглэлээр санал солилцсон бөгөөд уулзалтын мөрөөр "Роснефть" компанийн төлөөлөгчид 2018 оны 09 дүгээр сарын 26-наас 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо албан айлчлал хийж энэхүү төслийн талаар холбогдох байгууллага, төлөөлөгчидтэй уулзаж санал солилцож цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.	30		
9	10.3. . Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (салбар төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай, хашаа)-ын хүрээнд хийгдэх ажлыг батлагдсан ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төсвийн дагуу эхлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга хот байгуулалтын	Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 21 дүгээр тогтоолоор үйлдвэр байгуулахад шаардагдах гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18,2 км урттай 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий	100	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ	

		<p>сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт зөвшөөрч, уг дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг тухай бүр шуурхай шийдвэрлэж байхыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баярмагнай)-д даалгав.</p>	<p>дэд станц болон 16,6 км урттай хатуу хучилттай авто зам барих төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтын ажлыг тухайн ажлыг гүйцэтгэх туршлага, техник тоног төхөөрөмжийн чадавхтай төрийн өмчит хуулийн этгээдүүдээс сонгон хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд нарт даалгасан.</p> <p>Түүнчлэн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах санхүүжилтийг Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Одоогоор Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 17,5 км урт автозамын барилга угсралтын ажил 40%, цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил 90%, салаа төмөр замын ажил 40%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсний дагуу яамны зүгээс “газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Дээрх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийн барилга угсралтын ажлуудыг 2019 оны IV улиралд багтаан гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>		
10	10.4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган		<p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаа</p>	70	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн тайланг долоо хоног бүр гүйцэтгэгч компаниудаас гаргуулан авч хяналт тавьж ажиллаж байна. Мөн УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар “Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдөр хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн.		
--	--	--	---	--	--

Хэсгийн дундаж: 68,4 хувь

Салбар чиглэл: 5 – НИЙТЛЭГ АСУУДАЛ

5.а.Монгол Улсын хууль

		Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015-11-26 №: 2015.11.26	ХБТХуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т, энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална гэж заасан бөгөөд Үндэсний хөгжлийн газар нь журмыг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан ба журмын төслийг эцэслэн хүлээн аваагүй байна. УУХҮЯ нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, мэдээг яамны цахим хуудсанд тусгай цэсэнд тухай бүр байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100	Бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, мэдээг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллэж ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
1	1	22.2. Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.	Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан, "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.3, 2.1.4 дугаарт тусгагдсан аж үйлдвэр болон эрдэс баялгийн салбарын 4 зорилтын 9 үйл ажиллагааг тайлагнах хүснэгтийн мэдээллийг түүвэрлэн боловсруулж, холбогдох биелэлтийг гаргуулан, хэрэгжилтийн явцад х/ш/ү хийж, 2016-2020 он хүртэлх эхний үе шатны зорилтын хэрэгжилт 55.0 хувийн биелэлттэй дүгнэв. Холбогдох тайлан, танилцуулгыг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж,	100	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг Сангийн яаманд хүргүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

			2018.09.04-ний өдрийн 01/2340 тоотор СЯ-д хүргүүлж ажиллав.		
2	3	<p>Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 №: 2017.05.12</p> <p>8.6.2. 8.6. Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр албан даалгавраар</p> <p>"1. Үйлдвэрлэл эрхлэгчид:</p> <p>1.1. Үйлдвэрлэлийн шат дамжлагаас бий болж байгаа хог хаягдлыг дахин боловсруулах, хог хаягдал үүсгэхгүй байх дэвшилтэт технологийг ашиглахыг эрмэлзэх;</p> <p>1.2. Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх, аюулгүй ажиллагааны болон аюултай хог хаягдлын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>2. Яамны уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжүүд болон Ашигт малтмал, газрын тосны газар:</p> <p>2.1. Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны болон аюултай хог хаягдлын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, зөрчил гаргасан үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагатай хамтран хяналт шалгалт явуулж, хуульд заасан хариуцлага тооцох;</p> <p>2.2. Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн бол хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, удаа дараа ноцтой зөрчил гаргаж, гаргасан зөрчлөө арилгахгүй байгаа үйлдвэрлэл эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох, цуцлах хүртэл арга хэмжээг авах" үүрэг даалгаврыг өгч ажилласан.</p>	70	
5.б.Улсын Их Хурлын тогтоол					
1	1	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 №: 2016 №51</p> <p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил</p>	<p>"Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан яамны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудсанд байршуулсан.</p>	100	2018 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг

	<p>бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.</p>	<p>Иргэд олон нийтээс санал сэтгэгдэл хүлээж авах бүх боломж хангагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу: Төрийн жинхэнэ албан хаагчдын 2017 оны ХАСХОМ-ийг баталгаажуулж, тайланг АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэв. УУХҮЯ-ны 2018 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланг гаргаж, АТГ-т 2019 оны 1 дүгээр сард хүргүүлэхээр бэлтгэв. 2018 онд ХАСУМ хянуулсан албан хаагчдын бүртгэл, УУХҮЯ дээр 2018 онд зарлагдсан, худалдан авах ажил үйлчилгээний тендерийн үнэлгээний хорооны 28 гишүүний албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн бүртгэл, Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдаж, мэргэшсэн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, Ашиг сонирхлын хамааралтай албан хаагчдын судалгаа зэрэг судалгаануудыг хийлээ. 2018 онд 15 албан хаагч шинэчлэн буюу их хэмжээний өөрчлөлт орсоноор ХАСХОМ-ийг мэдүүлсэн байна. 2018 онд УУХҮЯ-аас шатлан дэвшсэн буюу шинээр нийтийн албанд нэр дэвшсэн 22 иргэнийг эхний 11 сард, шинэ бүтэц батлагдсантай холбогдуулан 12 албан хаагчийн “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” - ХАСУМ-ийг АТГ-т хүсэлт илгээн, хянуулав. ХАСУМ, тайлбар мэдэгдэл гаргасан этгээдийн мэдээлийг тухай бүрд нь цахим программд оруулж, АТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу шаардлагатай мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэв. АТГ, Монголын маркетингийн судалгааны ассоциаци ТББ хамтран УУХҮЯ дээр явуулсан “Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээ” судалгааны ажилд тусалж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, уулзалт ярилцлага зохион байгуулах зэргээр хамтран ажилласан.</p>	<p>хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
--	---	--	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

			АТГ-ын Олон нийтийн төвд 2018 оны 1-р улиралд зохион байгуулсан сургалтад 32 албан хаагч, 2-р улиралд 18 албан хаагч, 4-р улиралд 16, нийт 69 төрийн захиргааны албан хаагч хамрагдсан байна.		
2	2	Монгол Улсын 2018 төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2017.-11-14 №69  1.. 1/Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад "сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах" зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн "Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай" Б/52 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлж байсан бөгөөд Улсын Их хурлын 2017 оны 29 дүгээр тогтоол гарснаар төрийн албан хаагчдын цалингийн шатлал ахиулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг царцаасан. Улмаар Улсын Их хурлын 2018 оны 79 дугаар тогтоолоор холбогдох заалтуудыг хүчингүй болгосноор төрийн албан хаагчдад урамшуулал олгох асуудлыг судалж байна.	70	
5.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
1	1	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-11-23 №03  10. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэгт заасан усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хамрах хүрээг өргөтгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах, бүрэн эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх, дээр дурьдагдсан зөрчлүүдийг нэг мөр шийдэх үүднээс "Ашигт малтмалын тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай" хуулийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд энэхүү хуулийн зохицуулалтыг хийх хүртэл түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зогсоосон. Холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж байна.	100  Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зогсоож, холбогдох хуулийн төслийг боловсруулж байгаа тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	2	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-11-23 №: 2016_03	Заамар сумын нутаг дэвсгэрт, Туул голын сав газрын дагуу 19 хайгуулын тусгай зөвшөөрөл "Ашигт малтмалын тухай" хуулийн хүрээнд хүчин	100	

		Нэг. 3/ Туул голын сав газар, түүний ойр орчимд элс, хайрга олборлохыг зогсоох.	<p>төгөлдөр байна. Эдгээрээс 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 онд хайгуулын ажилд нийт дүнгээрээ 2,9 тэрбум төгрөг зарцуулсан байна.</p> <p>Мөн тус сумын нутагт олгогдсон алтны 84 хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас 2016 онд 42 тусгай зөвшөөрөл эзэмшигч уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн байна.</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нараас 2017 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 38 тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт явуулсан ба 28 тусгай зөвшөөрлийн талбай нь урт нэртэй хуулийн хамгаалалтын бүстэй хэсэгчилэн давхцалтай байгаа тул давхцалгүй хэсэгт үйл ажиллагаа явуулжээ.</p> <p>Үлдсэн ашиглалтын тусгай зөвшөөрөлүүд нь олборлолтоор ордын нөөц дууссан, хөрөнгө оруулалт байхгүйн улмаас зогссон болон хуулийн хүрээнд хамгаалалтын бүсүүдтэй давхцалтай гэх мэт шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулаагүй байна.</p>	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
5.г.Ерөнхийлөгчийн зарлиг					
1	1	Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай 2017-06-16 №136	<p>МУ-ын ерөнхийлөгчийн 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн зарлигийн дагуу Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг яамны нийт албан хаагчдад уриалан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	100	Зарлигийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
2	2	Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай 2018-04-11 №: 2018_38	АТГ, Монголын маркетингийн судалгааны ассоциаци ТББ хамтран УУХҮЯ дээр явуулсан “Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээ” судалгааны ажилд тусалж, шаардлагатай мэдээ,	100	Авлигын хор уршиг, хохирлыг

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		3. Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.	мэдээллээр хангах, уулзалт ярилцлага зохион байгуулах зэргээр хамтран ажилласан. АТГ-ын Олон нийтийн төвд 2018 оны 1-р улиралд зохион байгуулсан сургалтад 32 албан хаагч, 2-р улиралд 18 албан хаагч, 4-р улиралд 16, нийт 69 төрийн захиргааны албан хаагч хамрагдсан байна. 2018 онд ХАСУМ хянуулсан албан хаагчдын бүртгэл, УУХҮЯ дээр 2018 онд зарлагдсан, худалдан авах ажил үйлчилгээний тендерийн үнэлгээний хорооны 28 гишүүний албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн бүртгэл, Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдаж, мэргэшсэн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, Ашиг сонирхлын хамааралтай албан хаагчдын судалгаа зэрэг судалгаануудыг хийлээ.	ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
5.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл					
1	1	Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-01-08 Дугаар 2013_04/01  2.. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд мод, сөөг, сөөгөнцөр ургамал түлшинд хэрэглэхийг хязгаарлах зорилгоор түүхийн нүүрсийг гүн боловсруулж цэвэр түлшээр төв, орон нутгийг хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлэх.	Эрдэнэс монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр Тавантолгой түлш ХХК-ийг байгуулж, 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр үйлдвэрийн нээлтээ хийсэн. Уг үйлдвэр жилд 200 мянган тонн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай болно.	100  Шахмал түлшний үйлдвэр байгуулагдсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
2	2	Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 19/5  1. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон уг хуультай холбогдон гарсан бусад дүрэм, журам, зааврыг сонгон шалгаруулалтын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100  Холбогдох зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

		байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах.			
5.е.Засгийн газрын тогтоол					
1	1	<p>Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015-03-11 №94</p> <p>3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай:</p> <p>3.1. гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулах;</p> <p>3.2. усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалттай бүсийн хилийн заагийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай тогтоох;</p> <p>3.3. ашигт малтмалын нөөцийн тодотгол, техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг бүртгэх, хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах;</p>	<p>Энэхүү тогтоолын зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэхээр алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгөнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 256,0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкуудаар дамжуулан он дуустал олгоно. Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Уул уурхайн сайдын 2015 оны А138/273/206 тоот хамтарсан тушаалаар Алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн арга хэмжээ батлагдсан бөгөөд тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>2. Зээл хүссэн ААН-үүдийн жагсаалтыг эхний ээлжинд Монгол банкинд хүргүүлсэн. "Алт үйлдвэрлэгчдийн холбоо"-оор дамжуулан зээлийн хүсэлтүүдийг хүлээн авч судалгааг хийсэн. Монгол банк, Сангийн яамны зүгээс тохирсон схемийн дагуу санхүүжилтийг арилжааны банкинд олгоогүй байна.</p> <p>3.1. ЗГ-ын 2015.03.30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор "Журам, гэрээний загвар"-ыг батлуулсан. Мөн 235 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 04 сарын 21-ны өдрийн А-185 тоот тушаалаар Хилийн заагын тодорхойлолт гаргах, маргаан шийдвэрлэх комисс томилогдон газар дээр нь томилолтоор ажилласан. Мөн УУ-н Сайд, БОНХАЖ-ын Сайд нарын 97/А-227 тоот тушаалаар хамтарсан Ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>5. БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 04 сарын 21-ны өдрийн А-185 тоот тушаалаар Хилийн заагын тодорхойлолт гаргах, маргаан шийдвэрлэх комисс томилогдон ажиллаж байна. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг хуульд заасан</p>	<p>100</p> <p>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>3.4. "Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэн ажиллаж байгаа шороон ордыг ашиглах боломжийг судалж шийдвэрлэх.</p>	<p>200м-ын хилийг БОНХАЖЯам 1:100 000 масштабтай газрын зургаас татан буулгасан байна. Дэглэмийг мөрдөн ажилласан.</p> <p>3.3. Шуурхайлах зорилгоор АМГ-ын дотоод журамд өөрчлөлт оруулж, тойрох хуудас, хянах албан тушаалтны тоог цөөрүүлж, ирүүлсэн ААН-үүдийн бичиг баримтыг шуурхай хянан баталгаажуулсан.</p> <p>7.Уг тогтоолд хамрагдсан "Монполимет" ХХК-ийн Тосонгийн гольдролын алтны шороон орд, "Их тохойрол" ХХК-ийн алтны ордыг ашиглалтанд оруулах ажлыг эхлүүлэхээр урт нэртэй хууль болон холбогдох ЗГ-ын тогтоолуудын үйлчлэх хүрээнээс гаргах асуудлаар "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2015 оны 130 дугаар тогтоол батлуулсан.Тогтоолыг хэрэгжүүлэх ажил хийгдэж байна.</p>		
1	2	<p>Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>2015-03-11 №94</p> <p>4. Улсын хилийн зурвас болон тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай зарим ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судалж, саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт 2015 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нарт даалгасугай.</p>	<p>Дээрх тогтоолын дагуу Батлан хамгаалахын, Уул уурхайн сайдын хамтарсан тушаалаар Ашигт малтмалын ордыг эзэмших, ашиглах, хилийн зурвас, тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн зарим алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр тодорхой санал дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Хамтарсан ажлын хэсэг Уул уурхайн яаман дээр 3 удаа уулзаж санал солилцож ажилсан. Ажлын хэсгээс Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамаарах баттай, бодит боломжтой нөөцтэй алтны орд 51 илрэлүүдийг баттай, бодитой нөөцөөр нь ангилсан. Мөн Монгол Улсын хилийн дагуу 100 км бүсэд тогтоогдсон алтны ордуудын мэдээллийг АМГ-с гаргуулсан.</p>	100	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
2	3	<p>Албан татварыг хэсэгчлэн төлүүлэх тухай</p> <p>2015-05-18 №190</p>	<p>Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа "Монголын алт" ХХК-тай байгуулах гурвалсан гэрээний төсөл одоогоор тус</p>	70	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа “Монголын алт” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай.	яаманд ирээгүй байна. УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор тус ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон “Монголын алт” ХХК, “Эрдэнэс Цагаансуварга” ХХК-ийн хооронд 2015 оны 11 сард тус ордыг түшиглэн байгуулах Баяжуулах үйлдвэрийн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. /ХБНГУ-аас “Монголын алт” ХХК-д олгох зээлийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргасан/		
3	4	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2016-03-14 №: 2016_155  2. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.	Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь БОАЖЯ-ны эрх үүрэгт хамаарах бөгөөд тогтоолд өөрчлөлт орсон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн.	100	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
4	5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2016-10-26 №: 2016_121  3. Төлөвлөгөөнд тусгасан томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2017 онд багтаан эцэслэн боловсруулж 2018 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ш.Дашдорж, Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн засаг дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын	1. Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор УУХҮС-ын 2017 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлах тухай" А/22 дугаар тушаалыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. 2. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхээр шалгарсан БНХАУ-ын "Wuhuan engineering" компани нь төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж 2017 оны 5 дугаар сард УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн ба төслийн БОННУ-ны ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Green trends" ХХК нь 2019 оны 1 дүгээр улиралд багтаан тайланг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	100	Тогтоолын дагуу "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө"-г батлуулан, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсайхан нарт даалгасугай.			
5	6	<p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017-01-04 №6</p> <p>4. Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд зориулан Монгол Улсыг сурталчлах Mongolia@PDAC-2017 форумыг 2017 оны 03 дугаар сарын 5-ны өдөр Канад Улсын Торонто хотноо амжилттай зохион байгуулав. Тус форумд гадаад, дотоодын нийт 250 гаруй төлөөлөгчид оролцсон бөгөөд форумын үеэр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин, эдийн засаг, нийгмийн талаар төрийн төлөөлөгчид болон хувийн хэвшлийнхэн мэдээлэл өгч, ардын урлагийн "Хөсөгтөн" хамтлагийн тоглолтыг толилуулав.</p> <p>Австрали Улсын Засгийн газрын санхүүжилттэй АМЕР төсөлтэй хамтран Австрали Улсын Мелбурн хотноо 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд IMARC-2017 арга хэмжээг зохион байгуулж, УИХ, ЗГ, УУХҮЯ, АМГТГ болон бусад хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулав.</p> <p>Монгол-Хятадын 2 дахь удаагийн экспо арга хэмжээг Монгол Улсын ХХААХҮЯ, Үндэсний хөгжлийн газартай хамтран 2017 оны 09 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулж, салбарын томоохон компаниудын оролцох оролцоог хангав.</p>	100	Тогтоолд заасан хугацаанд холбогдох арга хэмжээнүүдийг зохион байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
6	7	<p>Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2017-03-15 №: 2017_83</p> <p>2. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржд нарт даалгасугай.</p>	<p>Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь БОАЖЯ-ны эрх үүрэгт хамаарах бөгөөд тогтоолд өөрчлөлт орсон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн.</p>	100	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
7	8	Журам батлах тухай 2017-04-12 №111	"Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"-ын дагуу тус яам нь Төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад албан бичгийг	100	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	цахимжуулан хүлээн авах, бүртгэх, явуулах, дамжуулах, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, мэдээ тайлан гаргах, цахим баримт бичгийг ангилан төрөлжүүлэх, албан хэрэг бүрдүүлэх, хадгалахдаа Able програмыг ашиглан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна. Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх үйл ажиллагаандаа Архивын тухай хууль, Монгол хэлний тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.	"Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам"-ын дагуу холбогдох программыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
8	9	Журам батлах тухай (түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам) 2014-07-09 №: 2014_222  2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг Зам, тээврийн яамнаас боловсруулж, батлуулсан бөгөөд журмыг мөрдөж ажиллаж байна.	100  Холбогдох журмыг мөрдөн ажиллаж байгаа тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
9	10	Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай 2017-01-25 №: 2017_27  4. Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	Тус тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүн 2017 онд хуралдаагүй болно. 2 дугаар хавсралтад заасан Стандартын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд БХЗГ-ын дарга томилогдон ажилласан. Стандартын үндэсний зөвлөл нь сар бүр хуралддаг бөгөөд тухай бүрийн хуралдаанд оролцож санал өгсөн. Стандартчиллын төлөвлөгөөт ажилд тусгагдсан "Улсын стандарт хянаж шинэчлэх" зорилготой 9 нэрийн цуврал стандартууд, "Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэд стандартыг орчуулж үндэсний болгох" зорилготой 9 нэр төрлийн, нийт 18 стандартын төслүүд ирүүлснийг судлан танилцаж, холбогдох шүүмжийг хийж, Техникийн хорооны хуралдаанд оролцон санал дүгнэлтээ танилцуулсан.	100  Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
10	11	Хөрс хамгаалах өдөртэй болох тухай 2017-05-24 №149 3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг улсын болон тухайн нутаг	2018 оны 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг "Хөрс хамгаалах үндэсний өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд АМГТГ-тай хамтран	/-/	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.		
11	12	Журам батлах тухай 2017-05-24 №: 2017_151  3. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай.	Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал, төлөвлөгөөний загварыг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/226-А/182 тоот тушаалаар баталсан.	100	Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал, төлөвлөгөөний загварыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
11	13	Журам батлах тухай 2017-05-24 №: 2017_151  4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт 10 чиглэлийн дагуу орон нутгийн удирдлагатай уулзалт зохион байгуулж ажилласан.	100	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

12	14	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2017-07-18 №208</p> <p>2. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн авто замаас Өлзийт, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн 120 км хатуу хучилттай авто замыг холбох ажил гүйцэтгэх “Шинжиан шинфа” ХХК-ийн 360, Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолтын ажил гүйцэтгэх “Петрочайна дачин тамсаг монгол” ХХК-ийн 176 гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд Монгол Улсад 2017 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт зөвшөөрсүгэй. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2017 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдэгдэхийг холбогдох сайд нарт даалгасугай.</p>	<p>Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 708 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах, мөн тус компанийн гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрлийн хугацааг 2 сараар бус он дуустал олгох асуудлыг тус тус шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичгийг ХНХЯ-д уламжлаад байна.</p>	<p>100</p> <p>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
13	15	<p>Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2017-12-13 №: 2017_337</p> <p>1. Төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1. Засгийн газраас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг ханган төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллаа. Үүнд:</p> <p>1. Засгийн газраас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль санаачлахгүй байх зарчим баримталсантай холбогдуулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулав. УУХҮ-ийн сайдын багцад 26.39 тэрбум төгрөг батлагдсаны 25.01 тэрбум төгрөгийг зарцуулж, 1.38 тэрбум төгрөгийн хэмнэлттэйгээр санхүүжүүлж, өр, авлага үүсгээгүй болно.</p>	<p>100</p> <p>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

	<p>төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль санаачлахгүй байх зарчим баримталж байгаатай холбогдуулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулах;</p> <p>1.2. төсвийн хууль тогтоомж зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өр үүсгэсэн болон тендер шалгаруулалтыг зохион байгуулж үнэлэхдээ холбогдох хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж, гарсан зөрчлийг тухай бүр залруулж ажиллах;</p> <p>1.3. арилжааны банк дахь бүх шатны төсвийн байгууллагын цалингийн болон жижиг мөнгөн сангийн данснаас бусад дансыг хааж, төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлэх, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн арилжааны банк дахь дансыг төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, цаашид төсвийн байгууллага арилжааны банкинд шинээр данс нээхгүй байх, төсвийн аливаа мөнгөн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдаж, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулан үр ашгийг нэмэгдүүлэх;</p> <p>1.4. улс, орон нутгийн төсөв, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр сар, улирлын хуваарийн дагуу жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч ажиллах;</p> <p>1.5. Улсын Их Хурлаас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан</p>	<p>2. Улсын төсөвт нийт 296.65 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 282.42 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр сар, улирлын хуваарийн дагуу төвлөрүүлж ажиллаа.</p> <p>3. төсвийн байгууллагын төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллав. Төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос геологи хайшуул судалгааны ажилд 3.9 тэрбум төгрөг, төсвийн тухай хуулиар баталсан бусад зардалд 0.6 тэр бум төгрөгийг зарцуулав.</p> <p>4. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй нийт 3.78 тэрбум төгрөгийн гэрээг байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, нийт 11.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.</p> <p>5. Худалдан авах ажиллагааг 100% цахимаар (<a href="http://tender.gov.mn">tender.gov.mn</a>) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээллэж, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг ханган ажиллаа.</p> <p>6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах бүх харьяа байгууллагуудын 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, тайлан, мэдээг хуулийн хугацаанд хүргүүлэхээр нэгтгэж байна.</p>		
--	--	--	--	--

	<p>татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон 2018 оноос хэрэгжиж эхлэх татварын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>1.6. төсвийн байгууллагын төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах;</p> <p>1.7. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх: а/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.4-т заасан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийг 2018 оны 1 дүгээр сарын 10-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх; б/ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлсэн байх; в/ худалдан авах ажиллагааг цахимаар (<a href="http://tender.gov.mn">tender.gov.mn</a>) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх; г/ бараа худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн</p>			
--	---	--	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцлан зохион байгуулах; д/төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн төсвийн багцад хамаарах бүх харьяа байгууллагуудын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлэх.</p> <p>1.8. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах чиглэлээр төсвийн ерөнхийлөн захирагч нар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх: а/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний байршил, хүчин чадлаас хамааруулан төсөвт өртгийн зөрүүг нягтлах ажлыг Барилга, хот байгуулалтын яамтай хамтран 2018 оны 1 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулах; б/ 2018 оны төсөвт тусгагдсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолоор баталсан нэг маягийн загвар зургийн дагуу хийгдэх төсөл, арга хэмжээний холболтын зураг төсвийн зардлыг тухайн барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд багтаан хэрэгжүүлэх; в/ төсвийн багцдаа батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс орон нутагт эрх шилжүүлэх ажлын жагсаалтыг 2018 оны 1 дүгээр сарын 5-ны дотор багтаан баталж, холбогдох байгууллагад хүргүүлэх.</p>		
14	16	<p>Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 №: 2018_20</p> <p>4. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон</p>	<p>Сангийн яамнаас тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байна. УУХҮ-ийн сайдын багцаас 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу төвлөрүүлж, 2018 онд 296.66 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 282.42 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, жилийн төлөвлөгөөний</p>	<p>100</p> <p>Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад</p>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.	хувьд 95.2%-ийн гүйцэтгэлтэй, байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тайлбайнуудын солбицлыг Засгийн газрын хуралдаанаас 8 сард баталсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын орлого буурсан тул төлөвлөсөн орлогоос 14.4 тэрбум төгрөгийн төвлөрүүлэлт буурсан болно.	ашиглаж байгаа тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
15	17	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 №: 2018_32  2.1 “Хариуцлагын жил”-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан холбогдох заалтын хүрээнд боловсруулан 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр сайдаар батлуулж мөрдлөг болгон ажилласан.	100  Яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан мөрдлөг болгон ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
15	18	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 №: 2018_32  2.2. яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах;	Тус яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, чиг хандлага, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулан гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажилсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 427 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 427 буюу хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл ба шийдвэрлэлт 98.7%-тай байна. Үүнтэй холбогдуулан удирдлагын шуурхай хуралдаанаар тус яамны сайд нийт удирдлагуудад иргэд, ААНБ-уудаас ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг	100  Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулан гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт ЗГХЭГ-т хүргүүлэн	

			<p>үүрэг болгосон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны 3 улирлын байдлаар нийт 345 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 213, цахимаар 3, биечлэн уулзсан 7 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 210, харъяалагдах чиг үүргийн дагуу бусад байгууллагад шилжүүлсэн 9, хугацаа болоогүй 7 өргөдөл, Ашигт малтмал газрын тосны газраас хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 8 өргөдөл буюу шийдвэрлэлт 94.1%-тай байв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосны дагуу Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах тухай 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 04/3016 тоот албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. Уг албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаврын 1.3, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 2.1, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2018 оны 01 тоот албан даалгаврын 3-т заасны дагуу төрийн албаны сахилга хариуцлагыг өндөржүүлэх үүднээс иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулан, шуурхай, цаг алдалгүй шийдвэрлэж ажиллах талаар үүрэг өгсөн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 746 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 734, цахимаар 3, биечлэн уулзсан 9 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 705, хугацаа болоогүй 41 өргөдөл, шийдвэрлэлт 100%-тай ба хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.</p>	ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
15	19	<p>2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 №: 2018_32 2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан</p>	<p>2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг нийт албан хаагчдаас 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргуулан авч 2019 оны 01 дүгээр сарын 08-ний өдөр баталгаажуулж дууссан. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагч 2018 онд байхгүй байна.</p>	100	<p>Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж ажилласан бөгөөд 2018 онд гэрээний</p>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх;		үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагч байхгүй тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
15	20	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 №: 2018_32  2.4. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах;	2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг 9 багцалж төсвийн жилд багтаан 100% хэрэгжүүлж, 100% санхүүжүүлж ажиллаа.	100  2018 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
15	21	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 №: 2018_32  2.5 “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Албан даалгаврын хэрэгжүүлэх хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 1 дүгээр албан даалгаврыг боловсруулан батлуулж нийт ажиллагсдын хуралдаан дээр танилцуулсан. Хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2018 оны 258 дугаар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллав. Төлөвлөгөөний хэрэгжилт 2018 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар 85%-тай байна. Төрийн албаны шинэчилсэн хуулийн хэрэгжилт, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ЗГХЭГ болон Төрийн албаны зөвлөлийн хамтарсан ажлын хэсэг 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр тус яаманд ирж ажиллан 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг гарган ажлын хэсэгт өгсөн.	100  Албан даалгаврын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
16	22	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тухай 2018-01-31 №: 2018_34	1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, тулгамдсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэх	100  2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл,	

	<p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай:</p> <p>1.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ижил хүчин чадал бүхий төслүүдийг нэг маягийн зургаар хэрэгжүүлж төсөвт өртгийн зөрүүг багасгах;</p> <p>1.2. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний холболтын зураг төсөв хийлгэх ажлыг яаралтай зохион байгуулж, нэг маягийн зураггүй төслүүдийг ойролцоо байршил, хүчин чадал бүхий нэг маягийн зурагт холболтын зураг, төсөв хийлгэж хэрэгжүүлэх;</p> <p>1.3. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний зураг, төсвийг шинээр боловсруулахад шаардагдах зардлыг барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд оруулан, 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан санхүүжүүлэх.</p>	<p>ажлын хэсгийг байгуулан, барилгын хяналтын инженерүүдтэй гэрээ байгуулан хяналт тавьж, 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан санхүүжүүлэв.</p>	<p>арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд ажлын хэсгийг байгуулан, 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан санхүүжүүлж ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
17	<p>23</p> <p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-05-23 №: 2018_138</p> <p>2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч,</p>	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгохыг кибер аюулгүй байдалтай хамтран хязгаарлалт хийж, хэрэглэгчийн компьютерийг домайнд оруулах, албан бичиг баримтыг тусгай төхөөрөмж болон программ хангамжаар дамжуулах асуудалд хяналт тавьж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.</p>	<p>100</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

10	14	2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл 2017-08-17  ХҮ1.3. 4. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлон байгаль орчинд ихээхэн хэмжээний хохирол учруулсан “Рич Мөнх” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах, байгаль орчинд учруулсан хохирлыг бүрэн тооцож нөхөн төлүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгов.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны “Гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллах” тэмдэглэлийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэстэй хамтран Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутагт усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлүүдэд “Төрийн хяналт шалгалтын тухай” болон холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газруудад хяналт	100  Холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

			шалгалтын талаарх мэдээллийг хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт ирүүлээгүй тул “Рич Мөнх” ХХК-ийн MV-020530 тоот тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байна. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг зөрчсөн аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг Улсын мөрдөн байцаах газрын Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс болон Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн шалгаж байна. Үүнд “Рич мөнх” ХХК-ийн MV-020530 тоот тусгай зөвшөөрөл орсон байна.		
11	15	2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2017-09-13  XXXII.2. 2 Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	УУХҮ-ийн сайдын 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг 3 дугаар улирлын байдлаар гарган УУХҮЯамны 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 03/2261 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан.	100	Худалдан авах ажиллагааны тайланг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
12	16	2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2017-11-01 №: 2017_46  III. Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулан Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын хуралдааны журам”-ыг баримталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт	2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш Засгийн газрын хуралдаанаар "Нүүрс тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай", "Налайхын нүүрсний уурхайн зарим нутаг дэвсгэрийг улсын тусгай хэрэгцээнд авах тухай", "Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны тухай" зэрэг асуудлуудыг холбогдох газартай хамтран хэлэлцүүлсэн бөгөөд ийнхүү хэлэлцүүлэхдээ Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын хуралдааны журам"-д заасны дагуу холбогдох яамдуудаас санал авч,	100	Холбогдох асуудлыг хэлэлцүүлэхдээ “Засгийн газрын хуралдааны журам”-ыг баримтлан ажилласан тул ХЯНАЛТААС

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		хянуулсны үндсэн дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.	тооцоо судалгаа хийсний үндсэн дээр танилцуулсан.	ХАСАХ САНАЛТАЙ.	
13	17	2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2018-01-10 №: 2018_3  ХҮҮ.2. “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн яамаар эцэслэн хянуулсны үндсэн дээр батлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгав.	2018 оны 02 дугаар 28-ны өдрийн 46 дугаар тушаалаар "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ыг баталж Хууль зүйн дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 3863 дугаарт бүргүүлсэн.	100  "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ыг ХЗДХЯ-аар эцэслэн хянуулсны үндсэн дээр баталсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
13	18	2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2018-01-10 №: 2018_3  ХҮҮ.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон байдлыг шалган судлах хамтарсан ажлын хэсэг байгуулж холбогдох мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгав.	УУХҮСайдын 2018.02.02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 1994-2017 оны ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын байдлыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох харилцааны эрх зүйн зохицуулалтуудад /Газрын хэвлийн тухай хууль (1988 он), Ашигт малтмалын тухай хууль (1994, 1997, 2006 он), түүний нэмэлт өөрчлөлтүүд/ тулгуурлан 4 бүлэгт шалган судалсан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон байдлын талаарх танилцуулгыг сайдад танилцуулж улмаар Ерөнхий сайдад мөн танилцуулсан.	100  Ажлын хэсэг байгуулан ажиллаж холбогдох танилцуулгыг Ерөнхий сайдад танилцуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
14	19	2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр 13 дугаар тэмдэглэл 2018-03-13 №: 2018_13  ҮИИ.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх улирлын чанартай төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган Сангийн сайд	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлснээр 2018 онд төлөвлөсөн 4 худалдан авалтыг амжилттай зохион байгуулж, 100%-ийн санхүүжилтийг олгоод байна. Тусгай ажлын хэсгийг байгуулж хяналт тавин ажилласан ба барилгын инженерүүдтэй хяналт тавих гэрээг байгуулан давхар хяналтыг тавьж, чанарын өндөр түвшинд гэрээний хэрэгжилтийг дүгнэн санхүүжүүлэв. Хөрөнгө оруулалтын	100  Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		<p>Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов: - улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх; -эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах; - хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэх.</p>	<p>гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд сар бүр хүргүүлж, шилэн дансанд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаа.</p>		
15	20	<p>2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 №: 2018_16</p> <p>ХҮ.2 Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.</p>	<p>Ажлын байранд ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох ажлын хүрээнд Checkpoint 1470 төхөөрөмжийн сүлжээндээ байршуулж, тохиргоог хийснээр нийт албан хаагчид ажлын байранд интернэт сүлжээ ашиглан олон нийтийн сүлжээ, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг нь хориглосон болно.</p>	100	<p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>

15	21	<p>2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 №: 2018_16</p> <p>ХҮҮ.9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:</p> <p>1. 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар “хангалтгүй” буюу 27.7 хувьтай байх тул тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах;</p> <p>1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах;</p> <p>1.2. өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх;</p> <p>1.3. худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах;</p> <p>1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 101-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах,</p>	<p>2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явцын мэдээг сар бүр гарган удирдлагад танилцуулж, Шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллав. 2018 онд зарласан тендерүүдийг 100% цахим системээр зохион байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд урилга, үр дүн, гэрээнүүдийг байршуулав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, тайланг Сангийн сайдын баталсан журмын дагуу нэгтгэж байна. 2018 оны худалдан авах ажиллагааг баталсан төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж байна. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, дотоодын үйлдвэрээс худалдан авсан барааны тайланг харьяа байгууллагуудаас авч нэгтгэж байна.</p>	<p>100</p> <p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
----	----	---	--	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.			
16	22	<p>2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2018-04-17 №: 2018_17</p> <p>ХҮ.1. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн I улирлын дүнг захиалагч нэг бүрээр нь Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. яамд хариуцан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, мөн аймаг, нийслэлд шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, эрчимжүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгав.</p>	Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, тендерийн явцын тайланг сар бүр гарган шилэн дансанд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллав. 4 төсөл, арга хэмжээний 9 багц тендерийг гомдол, саналгүйгээр зохион байгуулж, төсвийн жилд багтаан гэрээг дүгнэж, санхүүжилтийг 100% олгов.	100	Холбогдох худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
16	23	<p>2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2018-04-17 №: 2018_17</p> <p>ХҮ.2. 3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт: - Нүүрс олборлох, тээвэрлэх явцад байгаль орчинд учруулж байгаа хохирлыг багасгах, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах; -Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь байгалийн нөөц газрын улсын тусгай хамгаалалттай Тост, Тосон бумбын нурууны хилийн ойролцоох газар нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор ашигт малтмал</p>	Засгийн газрын шийдвэрийн дагуу 2018 оны 5 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Гурван тэс суманд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нар ажилласан. Нүүрс олборлох, тээвэрлэх явцад байгаль орчинд учруулж байгаа хохирлыг багасгах, бэлчээр хамгаалах үүднээс Өмнөговь аймгийн Баяндалай сумаас Ноён сумын нутагт үйл ажиллагаа эрхэлж буй "Терра энерги" ХХК хүртэлх 160 км авто замын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх тухай санал боловсруулж Үндэсний хөгжлийн газарт 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2566 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		ашиглах тусгай зөвшөөрлийг нэмж олгохгүй байх арга хэмжээ авах.			
16	24	2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2018-04-17 №: 2018_17  VIII.2. Гадаад харилцаатай холбоотой асуудлаар Гадаад харилцааны яамаар, төсөв, гадаадын зээл, тусламжийн асуудлаар Сангийн яамаар холбогдох журмын дагуу дамжуулан "нэг цонхны" зарчмыг хатуу баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.	УУХҮЯ-ны удирдлагын гадаад айлчлал, олон улсын арга хэмжээнд оролцох үеэр баримтлах удирдамж, уулзалтын ярианы сэдэвт тусгах асуудалд Гадаад харилцааны яамнаас тухай бүр чиглэл, санал авсан. Гадаад харилцааны чиглэлээр Монгол Улсаас гадаад улс оронд суугаа Элчин сайдын яам болон ижил төвшний гадаадын байгууллагатай харилцахдаа зохих журмын дагуу Гадаад харилцааны яамаар дамжуулан "нэг цонхны бодлого"-ыг баримтлан ажилласан.	100	Холбогдох асуудлаар "Нэг цонхны" зарчмыг баримтлан ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
17	25	Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-05-23 №: 2018_138  2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.	Ажлын байранд ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох ажлын хүрээнд Checkpoint 1470 төхөөрөмжийн сүлжээндээ байршуулж, тохиргоог хийснээр нийт албан хаагчид ажлын байранд интернэт сүлжээ ашиглан олон нийтийн сүлжээ, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг нь хориглосон болно.	100	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
18	26	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21  XXIX.1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлаас гарах үндсэн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Ж.Дамдинсүрэн тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахмад Ц.Төрбилэг нартай хамтран боловсуулж Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Мандахгэрэлд хянуулан	100	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС

		<p>баримт бичгүүдийн төсөлд санал өгөхийг Засгийн газрын гишүүдэд;</p>	<p>УУХҮС, Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны дарга бөгөөд УУХҮС Д.Сумъяабазараар батлуулан. ОБЕГ-аар дамжуулан бусад салбарын улсын албадын төлөвлөгөөтэй хамт Монгол улсын шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшинд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын дайчилгааны даалгаврын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан БХЯ-д батлуулахаар хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 67 дугаар тогтоолоор жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх Лхавга гарагийг газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах өдөр болгон тогтоож, тус өдөр, аврах ажиллагаанд хүн амыг сургаж дадлагжуулах ажлыг зохион байгуулах үүргийг мэргэжлийн байгууллагуудад Монгол Улсын Шадар сайдаас өгсөн. Дээрх үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын Дэд хурандаа Д.Мөнхбат, Хошууч Б.Болдбаатар, нартай хамтран яамны нийт ажилтан, албан хаагчдад 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, гамшиг осол гарсан үед хэрхэн аврагдах” сэдвээр мэдлэг дээшлүүлэх сургалтаас олгосон мэдлэгийг дадлагажуулах зорилгоор сургуулилтыг зохион байгуулсан.</p> <p>Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилт, гамшиг ослын талаарх сургалт, сургуулилтанд нийт ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулсан тухай илтгэх хуудсыг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.</p>	<p>ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
18	27	<p>2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16</p>	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 6 сарын 8-ны өдрийн ХЭГ/1313 тоотоор ирүүлсэн, бодлогын баримт</p>	<p>100</p>	

		<p>Дугаар 2018_21</p> <p>XXIX.2.3. Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.</p>	<p>бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан УУХҮЯ-ны үйл ажиллагааг дүгнэсэн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны жилийн биелэлтэд х/ш/ү хийж байна.</p>	<p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
18	28	<p>2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21</p> <p>XXIX.2.4. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав.</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлвэрийн сайдаас 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгавар өгсөн байна.</p>	<p>100</p> <p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
19	29	<p>2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 23 дугаар тэмдэглэл 2018-05-30 Дугаар 2018_23</p> <p>XXIX.1. . Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны I улиралд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын</p>	<p>Тус яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, чиг хандлага, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулан гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажилласан.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 427 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 427 буюу хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл ба шийдвэрлэлт 98.7%-тай байна. Үүнтэй холбогдуулан удирдлагын шуурхай хуралдаанаар тус яамны сайд нийт удирдлагуудад иргэд, ААНБ-уудаас ирсэн өргөдөл,</p>	<p>100</p> <p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулан гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт</p>	

		<p>дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.                  Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.</p>	<p>гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны 3 улирлын байдлаар нийт 345 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 213, цахимаар 3, биечлэн уулзсан 7 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 210, харъяалагдах чиг үүргийн дагуу бусад байгууллагад шилжүүлсэн 9, хугацаа болоогүй 7 өргөдөл, Ашигт малтмал газрын тосны газраас хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 8 өргөдөл буюу шийдвэрлэлт 94.1%-тай байв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосны дагуу Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах тухай 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 04/3016 тоот албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. Уг албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаврын 1.3, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 2.1, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2018 оны 01 тоот албан даалгаврын 3-т заасны дагуу төрийн албаны сахилга хариуцлагыг өндөржүүлэх үүднээс иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулан, шуурхай, цаг алдалгүй шийдвэрлэж ажиллах талаар үүрэг өгсөн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 746 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 734, цахимаар 3, биечлэн уулзсан 9 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 705, хугацаа болоогүй 41 өргөдөл, шийдвэрлэлт 100%-тай ба хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.</p>	<p>ЗГХЭГ-т хүргүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
20	30	<p>2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл                  2018-06-13                  Дугаар 2018_26                  ХҮ.1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах</p>	<p>Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 245 дугаар тогтоолыг батлуулсан бөгөөд Уг тогтоолын хүрээнд “Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе</p>	<p>100</p> <p>Холбогдох шийдвэрийг Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байгаа</p>	

		бэлтгэл хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулахтай холбогдсон баримт бичгийн төслүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу иж бүрнээр боловсруулж, Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Бат-Эрдэнэ, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт үүрэг болгов.	шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж ажиллаж байна.	тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
20	31	<p>2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл 2018-06-13 Дугаар 2018_26</p> <p>XIX.3. . Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор баталсан Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>3.1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов.</p>	<p>УУХҮС-ын эрхлэх асуудлаар Улсын Их Хурлын 2014 оны 01 сарын 16 өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан, “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор баталсан төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2015-2020/, Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан, “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийн хэрэгжилтэд х/ш/ү хийж яамны нэгдсэн тайлангийн хамт 2018 оны 03 сарын 30-ны өдрийн 02/865 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлж ажиллав. Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хугацаа 2016 онд дуусгавар болсонтой холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны Б/101 дүгээр тушаалаар “Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого”-ыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, “Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж 2018 оны 6 сарын 6 өдрийн 169 дүгээр тогтоолоор батлуулсан. Улсын Их Хурлын 2009 оны Дугаар 45 тогтоолоор батлагдсан, төрөөс</p>	<p>100</p> <p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

			цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2009 оны 222 дугаар тогтоолоор бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталсан байна. Мөн уг тогтоолоор хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн газар /хуучнаар/-т хариуцуулсан байна. Үүний дагуу Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, Цөмийн энергийн комисс нь дээрх бодлогын хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна.		
21	32	<p>2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29 Дугаар 2018_36</p> <p>XIY.1. . Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны эхний хагас жилд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.</p>	<p>Тус яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, чиг хандлага, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулан гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт ЗГХЭГ-т хүргүүлэн ажилласан.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 427 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 427 буюу хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл ба шийдвэрлэлт 98.7%-тай байна. Үүнтэй холбогдуулан удирдлагын шуурхай хуралдаанаар тус яамны сайд нийт удирдлагуудад иргэд, ААНБ-уудаас ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны 3 улирлын байдлаар нийт 345 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 213, цахимаар 3, биечлэн уулзсан 7 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 210, харъяалагдах чиг үүргийн дагуу бусад байгууллагад шилжүүлсэн 9, хугацаа болоогүй 7 өргөдөл, Ашигт малтмал газрын тосны газраас хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 8 өргөдөл буюу шийдвэрлэлт 94.1%-тай байв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосны дагуу Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах тухай 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн</p>	100	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.

			04/3016 тоот албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. Уг албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаврын 1.3, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 2.1, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2018 оны 01 тоот албан даалгаврын 3-т заасны дагуу төрийн албаны сахилга хариуцлагыг өндөржүүлэх үүднээс иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулан, шуурхай, цаг алдалгүй шийдвэрлэж ажиллах талаар үүрэг өгсөн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 746 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 734, цахимаар 3, биечлэн уулзсан 9 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 705, хугацаа болоогүй 41 өргөдөл, шийдвэрлэлт 100%-тай ба хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.		
21	33	2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29 Дугаар 2018_36  ХҮ.. Улаанбаатар хотод 2018 оны 5 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 6 дугаар хуралдааны дүнг хэлэлцээд хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	“Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий хоёр орны Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 6 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо 2018 оны 5 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Тус хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдөр батлуулж, ГХЯ, Сангийн яам, ЭХЯ, БСШУСЯ, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам болон Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсэн.	100  Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

22	34	<p>2018 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2018-10-03 Дугаар 2018_41</p> <p>XXIII.5. . “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав.</p>	<p>“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн зохион байгуулсан болно.</p>	<p>100</p> <p>“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн зохион байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
5.3.Засгийн газрын албан даалгавар					
1	1	<p>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01</p> <p>1. Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна: 1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврыг 10 дугаар сарын 30-ны өдрийн яамны удирдлагын шуурхай хуралдаан дээр танилцуулж, яамны нийт албан хаагчдад танилцуулж, мөрдөж ажиллах талаар Төрийн нарийн бичгийн дарга үүрэг өгсөн. 11 дүгээр сарын 01-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Яамны нийт албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллахыг сануулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй танилцуулан баталгаажуулж, нийтийн албан хаагчийн хувийн хэргийн материалд хавсаргасан.</p>	<p>100</p> <p>Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

1	2	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  1.2 1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. Нийт ажиллагсадаас Авлигатай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд ХАСХОМ болон бусад холбогдох мэдээллийг гаргуулан хяналт тавин ажиллаж байна.	100	Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
1	3	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  1.3 1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;	“Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг хуулийн хугацаанд өгч ажиллаж байна. 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар яамны нэр дээр “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д нийт 51 санал, хүсэлт ирсэн бөгөөд 49-д нь хариу өгч, 12 дугаар сарын 12-нд ирсэн 2 асуудалд Геологийн бодлогын газар хариу албан бичиг бэлтгэж байна.	100	“Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн ажилласан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
1	4	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  1.4. 1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;	Төрийн албаны үр ашгийг сайжруулах, ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах ажлын хүрээнд 12 дугаар сарын эхний 7 хоногт 3 удаа цагийн бүртгэлийг хоцрогдсон албан хаагч тус бүрээр гаргаж, шалтгааныг тодруулж, хүндэтгэх шалтгаангүй ажлаас хоцорсон албан хаагчдад сануулах арга хэмжээ авсан. Мөн Монголын хүний нөөцийн институттай хамтран “Цагийн менежмент” сэдэвт сургалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан.	100	Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
1	5	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01	Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллаж байна. 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар	100	Албан даалгаврын дагуу холбогдох

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		1.5. 1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	хууль зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан явдал илрээгүй байна.	арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	6	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;	Яамны ажиллагсдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг холбогдох бүтцийн нэгжийн дарга нараар дүгнүүлж, дараагийн шатны дарга /Төсвийн шууд захирагч/-д танилцуулж баталгаажуулсан.	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	7	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  2.2 2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны зарлал, явцын мэдээ, үр дүнг яамны бодлогын газрууд /ГБГ/ Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлж ил тод байдлыг ханган ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгох үүднээс 2017 оны 11 дүгээр сарын 10-нд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгодог байсныг өөрчлөн сонгон шалгаруулалтаар олгохоор болсон бөгөөд энэхүү хуулийн хэрэгжилтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах болно.	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	8	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  2.3 2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй	Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх зарчмыг өдөр дутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

		байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;	ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, яамны үйл ажиллагааг дотоодод болон гадаадад сурталчлах, танилцуулах чиглэлээр байгууллагын вэб хуудсанд цаг үеийн мэдээллийг тухай бүр оруулж, “Ил тод уул уурхай” сэдэвт хэвлэлийн бага хурлыг сар бүрийн эхний долоо хоногийн даваа гараг бүр яаман дээр зохион байгуулан ажиллаж байна.	ХАСАХ САНАЛТАЙ.	
1	9	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  2.4 2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;	Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтан байхгүй болно.	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	10	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  2.5 2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.	Яамны ажиллагсдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг холбогдох бүтцийн нэгжийн дарга нараар дүгнүүлж, дараагийн шатны дарга /Төсвийн шууд захирагч/-д танилцуулж баталгаажуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбон ажиллаж байна.	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
1	11	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01  3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.	Төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг харьяалах төсвийн байгууллагад хүргүүлж ажилласан.	100  Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

1	12	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 №: 01 5. Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна.	Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг гарган ЗГХЭГ-т 03/2622 тоот албан бичгээр 12 дугаар сарын 11-ны өдөр хүргүүлсэн болно.	100 Албан даалгаврын хэрэгжилтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
<u>Хэсгийн дундаж: 98,4 хувь</u>					
НИЙТ ДУНДАЖ: 87.8 хувь					

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2019 он